**МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД, СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХООРОНД БАЙГУУЛСАН ГЭРЭЭ-2026**

| № | Гэрээний заалт | Агуулга | Зарцуулсан хөрөнгө | Шалгуур үзүүлэлт | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /Хүрээгүй бол тайлбар/ |
|---|---|---|---|---|---|---|
| **ГУРАВ. ЗАСАГ ДАРГЫН ЭРХ, ҮҮРЭГ** | | | | | | |
| 1 | 3.1 | Хэрэгжүүлэгч нь Эрүүл мэндийн тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө, эрүүл мэндийн чиглэлээрх арга хэмжээний төлөвлөгөө зэрэгт тусгагдсан үйл ажиллагааг орон | Улсын төсөв | Тогтоол, тушаал, зөвлөмж, үүрэг даалгаврын хэрэгжилт | Засгийн газрын тогтоол, сайдын тушаал, зөвлөмж, чиглэл, үүрэг даалгаврыг хэрэгжүүлж ажилласан байна. | “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө, эрүүл мэндийн чиглэлээрх арга хэмжээний төлөвлөгөөний хүрээнд<br>1. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны 74-р тогтоолоор “Сэлэнгэ аймгийн 2026-2030 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл”-д 7 арга хэмжээ,<br>2. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 52-р тогтоолоор “Сэлэнгэ аймгийн 2026 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөн”-д 17 арга хэмжээ,<br><br>Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 16-р тогтоолоор Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-д 14 арга хэмжээг тусган хэрэгжүүлэн |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | нутгийн хэмжээнд хэрэгжүүлэн Захиалагчийн өмнө хариуцна. | | | | ажиллаж байна. Хэрэгжилт 67,7% байна.<br><br>“Цахим эрүүл мэнд” төслийн хүрээнд аймгийн Нэгдсэн эмнэлэг, Мандал сумын Нэгдсэн эмнэлэг “E-Health” программыг нэвтрүүлснээр амбулаторийн цахим бүртгэл, үзлэгийн кабинетууд болон тасгууд, лаборатори хоорондоо цахимаар холбогдон оношилгоо, үзлэгийн дугаар авах, шинжилгээнд илгээх, хариу авах, яаралтай тусламжийг эрэмбэлэн цаг алдалгүй оношилгоо шинжилгээнд илгээх, хариуг хүргэх ажлууд шуурхай болсон.<br><br>2026 оны эхний 5 сарын байдлаар иргэн 123227 цаг бүртгүүлэн, 114126 иргэнд үйлчилгээ үзүүлэн, и-монголиагаас 772 иргэн, утсаар 4388 хүн цаг аван үйлчилгээнд хамрагдсан байна.<br><br>**Хэрэгжсэн** |
| | 3.2 | Төрийн албаны тухай хуулийн 53 дугаар зүйл, Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолын дагуу Эрүүл мэндийн байгууллагын дунд хугацааны бодлогын баримт бичигт Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахад дэмжлэг | Улсын төсөв | Хамтран ажилласан байгууллагын тоо | Салбар дундын хамтын ажиллагаа нэмэгдэнэ. | Эрүүл мэндийн байгууллагуудын дунд хугацааны бодлогын баримт бичиг Стратеги төлөвлөгөөг 2020 оны 04 сарын 15 өдрийн 32 тоот тушаалаар баталж хэрэгжилт 76 хувьтай байна |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | үзүүлж хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана. | | | **Хэрэгжсэн** |
| | 3.3. | Харьяалах нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагын удирдах ажилтныг хууль журмын дагуу сонгон шалгаруулалтаар томилж, хүний нөөцийн тогтвортой байдлыг хангана. | Улсын төсөв | Хамтран ажилласан байгууллагын тоо | Албан хаагчид тогтвор суурьшилтай ажиллана. | Эрүүл мэндийн сайдын 2025 А/371 тоот тушаалын дагуу Эрүүл мэндийн газрын даргын 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн Б/10 тоот тушаалаар эрүүл мэндийн төвийн даргын албан тушаалын тодорхойлолтыг батлан сумдын Засаг дарга нарт хүргүүлэн ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд Рашаант, Түнхэл тосгоны эрүүл мэндийн төвийн дарга нарын сул ажлын байрыг төрийн албаны салбар зөвлөлөөр зарлуулан сул орон тоог нөххөөр ажиллаж байна. **Хэрэгжсэн** |
| | 3.4. | Өөрийн харьяа нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа эрүүл мэндийн байгууллагын хүний нөөцийн хангалт, тогтвортой байдалд анхаарлаа хандуулж тэдний нийгмийн баталгаа, ажиллах нөхцөлийг дэмжиж ажиллана. | Улсын төсөв | Албан хаагчид тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ. | Хүний нөөцийн хангалт, тогтвортой байдалд нийгмийн баталгаа, хангагдсан байна. | Сэлэнгэ аймгийн Эрүүл мэндийн салбар нь нийт 97 төр хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагаас бүрдэж нийт 1423 ажиллагчид Сэлэнгэ аймагт оршин суугаа 103,831 хүн амд эрүүл мэндийн анхан болон лавлагаа шатлалын нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна. Сум тосгон өрхийн эрүүл мэндийн төвүүдийн хүний нөөцийн хангалт стандартын дагуу их эмч 94%, сувилагч 95%-н хангалттайгаар ажиллаж байна.<br>Аймгийн нэгдсэн эмнэлэг нь хүний нөөцийн хангалт стандартын дагуу их эмч 81%, сувилагч 81%-н хангалттай, Мандал сумын нэгдсэн эмнэлэг нь их эмч 97%, сувилагч 98%-н хангалттайгаар ажиллаж байна.<br>Их эмч сувилагчийн харьцаа 1:1,4 бөгөөд 10,000 хүн амд ногдох их эмч 26,9, сувилагч 36,3 байна.<br>2026-2027 оны хичээлийн жилийн хаврын элсэлтэд Дотоод шүүрэл судлал, Хүүхдийн эрчимт эмчилгээ судлалаар 2 их эмчийг |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төрөлжсөн мэргэшил олгох сургалтад, эмэгтэйчүүдийн хэт авиа судлалаар 1 их эмчийг дээшлүүлэх сургалтад, яаралтай түргэн тусламж, хүүхэд, гэмтэл, клиник биохимийн лаборантын сувилахуй судлалаар 7 сувилагч, мэс засал, сэргээн засах эмчилгээ, эх баригчийн сувилахуйн дээшлүүлэх сургалтад 3 сувилагч, шүдний туслах сувилагчаар 9 эмнэлгийн мэргэжилтэнг бэлтгэсэн байна.<br>Гадаад сургалтад БНХАУ-н хөх хотод 16 эмч, сувилагч, Хон конг 1 их эмч, Японд 2 их эмч, Тайвань 1 их эмч, Флипинд 1 эмч , БНХАУ 1 их эмч нийт 22 эмч, эмнэлгийн мэргэжилтэнг хамруулсан байна. Хүний нөөцийн тогтвортой ажиллах байдлыг хангах зорилгоор эмнэлгийн ажилчдын байртай Жавхлант 4, Түшиг 3, Түнхэл 3, Ерөө 1, Хушаат 2, Хэрх 3, нийт 16 эмч эмнэлгийн мэргэжилтэн албан хаагчийн тог цахилгааны мөнгийг байгууллагаас төлдөг, Сайхан ЭМТ 2, Алтанбулаг 2 албан хаагчийн байгууллагын байранд амьдруулж түрээс болон урсгал зардалыг байгууллагаас шийдэн амьдруулж байна. мөн ипотекийн зээлд 4 эмнэлгийн мэргэжилтэнг хамруулсан.<br>Эрүүл мэндийн сайдын А/513 тушаалын хэрэгжилтийг ханган Эрүүл мэндийн хөгжлийн төв, Монголын сувилагчдын нийгэмлэгтэй хамтран 2026 онд зэрэг горилох 62 эмч эмнэлгийн мэргэжилтэнд танхимын сургалтыг зохион байгуулан ажилаллаа. Тус сургалтын үр дүнд Зөвлөх зэрэг 3, Тэргүүлэх зэрэг 5, Ахлах зэрэг 15, дүйцүүлэхээр 1 нийт 24 эмч эмнэлгийн мэргэжилтэн зэргээ амжилттай хамгаалсан байна.<br>Тогтвор суурьшилтай ажилласан эмч, эмнэлгийн мэргэжилтэнд олгодог 3 болон 5 жилийн мөнгөн |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тэтгэмжийг 180,500,000 сая төгрөгийг олгосон байна. Мөн эмч, мэргэжилтнүүдийн хөдөлмөрийн хөлсийг холбогдох хууль эрхзүйн хүрээнд тогтмол хугацаанд нь өгөхийн зэрэгцээ илүү цаг, хавсран ажилласан, төрийн алба хаасан, орон нутгийн нэмэгдэл, хоолны хөнгөлөлт зэрэг нэмэгдэл, нэмэгдэл цалин, урамшуулал, нөхөх төлбөрийг төсвийн хүрээнд зохих журмын дагуу олгож нийгмийн баталгааг нь хангаж байна. **Хэрэгжсэн** |
| | 3.5. | Эрүүл мэндийн байгууллагын барилга шинээр ашиглалтад орсон тохиолдолд хуучин байрыг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд ашиглахгүй байх, Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20.1.8, 21.1.16 дахь заалтын дагуу төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагын барилга байгууламж, ашиглалт, засвар үйлчилгээний ажлын санхүүжилтийг бүрэн | Улсын төсөв | Хууль, тогтоол, тушаал, зөвлөмж, үүрэг даалгаврын хэрэгжилт | Хууль, Засгийн газрын тогтоол, сайдын тушаал, зөвлөмж, чиглэл, үүрэг даалгаврыг хэрэгжүүлж ажилласан байна. | 2026 оны эхнэий хагас жилийн байдлаар шинээр барилга ашиглалтад ороогүй байна.<br>Орон нутгийн санхүүжилтээр эрүүл мэндийн байгууллагын тогтмол зардалд 2,1 тэрбум төгрөг, урсгал засварын зардалд 210 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн авч ажилласан. **Хэрэгжсэн** |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | шийдвэрлэн ажиллана. | | | | |
| | 3.6. | Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой үүссэн өр, авлагыг барагдуулан шинээр өр үүсгэхгүй, санхүүгийн сахилга баттай ажиллах | Улсын төсөв | Тогтоол, тушаал, зөвлөмж, үүрэг даалгаврын хэрэгжилт | Засгийн газрын тогтоол, сайдын тушаал, зөвлөмж, чиглэл, үүрэг даалгаврыг хэрэгжүүлж ажилласан байна | • Засгийн газраас гаргасан үүрэг даалгавар, хэмнэлтийн хуулийн хэрэгжилтийг ханган, чиглэлийг бүх шатны эрүүл мэндийн байгууллагад хүргүүлэн ажилласан.<br>• Эрүүл мэндийн яамнаас баталсан хязгаарт нийцүүлэн бүтэц, орон тоог Засаг даргаар батлуулдаг тогтолцоог хэвшүүлснээр цалингийн өр, авлага үүсэх эрсдэлийг бууруулсан.<br>• Төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр нэгтгэн Эрүүл мэндийн яаманд хүргүүлсэн.<br>• 2026 оны 6 сарын байдлаар Эрүүл мэндийн даатгалын газраас 3,0 тэрбум төгрөгийн авлагатай 3,0 тэрбум төгрөгийн өглөгтэй байна. Өглөгийн 94,3 хувийг АНЭ эзэлж байна. Лавлагаа шатлалын эмнэлгийн ЭМДҮЗ-н шинэчлэл хийгдээгүй, цалин хөлсний нэмэгдэлтэй холбоотойгоор санхүүгийн ачаалал өссөн.<br>• Өр авлагын мэдээг сар бүр, шаардлагатай үед тухай бүр мэдээлэл гарган Эрүүл мэндийн яаманд хүргүүлж, санхүүгийн сахилга батыг хангаж ажиллаж байна.<br>**Хэрэгжээгүй** |
| | 3.7. | Эрүүл мэндийн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх ялангуяа ядуу, эмзэг бүлгийн иргэд, | Улсын төсөв | Сургалтыг тасралтгүй зохион байгуулсан тоо | Сайдын тушаал, зөвлөмж, чиглэл, үүрэг даалгаврыг | 2026 оны 05 сарын 31-ний байдлаар 2955 тодорхой ажил хөдөлмөр эрхлээгүй иргэн болон хувиараа хөдөлмөр эрхлэгч 2378 иргэн хамрагдаж эрүүл мэндийн даатгалын шимтгэлд 409,4 сая төгрөг төлснөөр хамралтын хувь - **80,5%**<br>6 гадаадын иргэн хамрагдахаас 2 иргэн |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгч, их дээд сургууль, коллеж, мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн суралцагчдын хамрагдалтыг нэмэгдүүлэх, энэ чиглэлээр орон нутгийн удирдлага иргэдтэй хамтран ажиллаж эрүүл мэндийн даатгалын талаар мэдээлэл, сурталчилгааны ажил тогтмол зохион байгуулна. | | | хэрэгжүүлж ажилласан байна | хамрагдаж эрүүл мэндийн даатгалын шимтгэлд хамралтын хувь - **33,3%**<br>Нийт хамралтын хувь 81%, өөрөө шимтгэлээ хариуцант төлдөг иргэдийн орлогын төлөвлөгөөний биелэлт **91,5%**<br>Мөн хэлтэс дээр биечлэн ирж болон утсаар зөвлөгөө авсан 152 иргэнд шимтгэлээ И-БАРИМТ аппликэйшнээр хэрхэн шалгах төлөх талаарх мэдээллийг хүргэж газар дээр нь шимтгэлийг төлүүлж, өөрсдөө тухайн аппликэйшнийг ашигладаггүй даатгуулагчдад хэлтсийн мэргэжилтнүүд ибаримт сайтыг ашиглаж шимтгэлийг төлүүлж байна. Мандал сумын НД-н тасагтай хамтран төр төсөв, аж ахуйн нэгж байгууллагын нягтлангуудад ЭМД-н тухай хуулийн хэрэгжилт, тусламж үйлчилгээний төрлүүдийн талаар мэдээлэл өгч сургалт зохион байгуулж нийт 48 хүнийг хамруулсан. Гэрээ бүхий 65 байгууллагад ОНХХ-ээс бэлтгэж хэвлүүлэн хүргүүлсэн сурталчилгааны зурагт хуудсыг гарын үсэг зуруулан хүлээлгэн өгч иргэдэд харагдахуйц газруудаар байршуулж сурталчилж байна.<br>**Хэрэгжсэн** |
| | 3.8. | Харьяа нутаг дэвсгэрийн эрүүл эрүүл мэндийн байгууллагын бүтэц зохион байгуулалт, өмчийн харьяалал өөрчлөх, төрийн өмчит байгууллага шинээр байгуулах, хүчин чадлыг нэмэгдүүлэх | Улсын төсөв | Тогтоол, тушаал, зөвлөмжийн дагуу ажиллах | Сайдын тушаал, зөвлөмж, чиглэл, үүрэг даалгаврыг хэрэгжүүлж ажилласан байна. | Харьяа нутаг дэвсгэрийн эрүүл эрүүл мэндийн байгууллагын бүтэц зохион байгуулалт, өмчийн харьяалал өөрчлөх, төрийн өмчит байгууллага шинээр байгуулагдаагүй.<br>**Хэрэгжсэн** |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | тохиолдолд Захиалагч талд харилцан зөвшилцсөний үндсэн дээр шийдвэрлэнэ. | | | | |
| | 3.9. | Төрийн бүх шатны байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн оролцоотой хуулийн этгээдийн авлигатай тэмцэх төлөвлөгөөний хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллана. | Улсын төсөв | Тогтоол, тушаал, зөвлөмж, төлөвлөгөөний дагуу ажиллах | зөвлөмж, чиглэл, үүрэг даалгаврыг хэрэгжүүлж ажилласан байна | Сэлэнгэ аймгийн Эрүүл мэндийн салбарын авлигын эсрэг 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 5 зорилго 12 зорилтын хүрээнд батлуулан бүх шатны эрүүл мэндийн байгууллагад хүргүүлэн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.<br><br>**Хэрэгжсэн** |
| | 3.10. | Шүгэл үлээхийг дэмжих зорилгоор мэдээлэл өгөх суваг, хамгаалалтын арга хэлбэр, ач холбогдлын | Улсын төсөв | Хууль сурталчилан таниулсан үйл ажиллагааны тоо | 1 | Авлигалтай тэмцэх газраас бэлтгэсэн шторк, инфографик, нийтлэл зурагт хуудас, цахим ном гарын авлага зэргийг албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк)-д байршуулж збүхий л болмжтой хэлбэрээр олон нийтэд хүргэн ажиллаж байна.<br>Мөн байгууллагын өргөдөл гомдол авах ажилтаны мэдээллийг нийтэд ил тод байршуулан ажиллаж байна.<br>**Хэрэгжсэн** |
| **3.11 Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чиглэлээр** | | | | | | |
| | 3.11.1 | Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийг хангах, аймгийн эрүүл | Улсын төсөв | Хууль сурталчилан таниулсан үйл ажиллагааны тоо | 6 | Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хуулийг сурталчлан таниулах зорилгоор Аймгийн ЗДТГ, Аймгийн ИТХ-ын зөвлөл, сум тосгоны эрүүл мэнд, боловсролын байгууллагын удирдлага албан хаагч, иргэдэд зохион байгуулсан Тус үйл |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | мэндийн газрын харьяанд Нийгмийн эрүүл мэндийн бие даасан төв байгуулах бэлтгэл ажлыг хангах, хуулийг сурталчлан таниулах үйл ажиллагааг өргөнөөр зохион байгуулна | | Нийгмийн эрүүл мэндийн төв байгуулах бэлтгэл ажлын хувь | | ажиллагаанд 8 байгууллагын 253 гаруй албан хаагч иргэд хамрагдсан.<br>Аймгийн Засаг даргын 2026 оны А/34 тоот захирамжаар 7 хүний бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.<br>Нийгмийн эрүүл мэндийн төвийн барилгын ажлын зураг, төсвийг улсын төсөвд тавих талаар төвийн бүсээс сонгогдсон УИХ-ын гишүүдэд танилцуулсан. Хүний нөөцийг нэмэгдүүлэх хүрээнд аймгийн “Чадварлаг эмч, эмнэлгийн мэргэжилтэн” арга хэмжээний дагуу ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад сургалт зохион байгуулсан. Сургалтад нийт 200 гаруй сурагчид хамрагдсан.<br>Улсын хэмжээнд нийгмийн эрүүл мэндийн төв байгуулах загвар бүтэц орон тоо, төсөв батлагдаагүй байна. Бэлтгэл ажил 10%<br>**Хэрэгжсэн** |
| | 3.11.2 | Хүн амын дунд эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлэх чиглэлээр сургалт сурталчилгаа, нөлөөллийн арга хэмжээг иргэн, аж ахуйн нэгж байгууллага, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран тогтмол зохион байгуулна. | Улсын төсөв | Сургалт сурталчилгаа, нөлөөллийн ажлын тоо<br>Нийт хүн амын хамрагдалтын хувь | 15<br>20% | 2026 оны эхний хагас жилийн байдлаар хүн амын дунд эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлэх чиглэлээр **43** удаагийн танхимын сургалтыг зохион байгуулж аймгийн нийт хүн амын **29,9%** буюу **31458** хүнийг хамруулаад байна. Үүнд:<br>Бага насны хүүхдийн эрт илрүүлэг үзлэг, дархлаажуулалт, эцэг эхчүүдэд чиглэсэн сургалт, эмнэлзүйн хоол эмчилгээ, илчлэг тооцох аргачлал, яаралтай тусламж, иргэдэд зориулсан эрүүл зохистой хооллолт, хүнсний аюулгүй байдлын зөвлөмж, гэр бүл төлөвлөлт, нөхөн үржихүйн эрүүл мэнд, сүрьеэ, гэмтлийн тусламж үйлчилгээг сайжруулах, чихрийн шижингийн өөрийн хяналт, анхаарах асуудал, амны хөндийн эрүүл мэнд, архинд донтох эмгэгтэй иргэдэд чиглэсэн уулзалт, ажлын байран дахь бэлгийн дарамтаас сэргийлэх, гэр |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бүл төлөвлөлт, үр хөндөлтийн хор уршиг, бэлгийн замаар дамжих халдвараас сэргийлэх, эрүүл мэнд, худалдаа үйлчилгээ, үйлдвэрлэлийн эрүүл ахуй, халдвар хамгааллын дэглэм зэрэг сэдвүүдээр сургалт, нөлөөллийн ажлууд хийгдсэн ба арга хэмжээний үр дүнд дээд шатлалын эмнэлгүүд, төр, хувийн хэвшлийн байгууллагуудын уялдаа, хамтын ажиллагаа сайжирч, нийт иргэдийн 29,9%-д хүрч ажиллалаа.<br>**Хэрэгжсэн** |
| | 3.11.3 | Зорилтот бүлэгт насны ангиллын дагуу зохион байгуулж байгаа “Урьдчилан сэргийлэх, эхт илрүүлэх үзлэг, оношилгоо” арга хэмжээнд өөрийн харьяа нутаг дэвсгэрийн хүн амыг бүрэн хамруулж, иргэл болон ажил олгогчдыг идэвхжүүлэх, энэ чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлэн санаачилгатай ажиллана<br>✓ Ургийн гажгийн эрт илрүүлэг | Улсын төсөв, Эрүүл мэндийн даатгалын санхүүжилт | Эрт илрүүлэг үзлэг шинжилгээнд хамрагдсан хүний тоо | Эрт илрүүлэг үзлэг шинжилгээний хамрагдалт нэмэгдсэн байна. | Эрүүл мэндийн сайдын 2025 оны 05 тушаал тушаалын дагуу дээрх зорилтот бүлэг рүү чиглэсэн эрт илрүүлэг үзлэг зохион байгуулагдах бөгөөд эрүүл мэндийн даатгалын санхүүжилт шийдэгдээгүй тул хорт хавдрын болон сургуульд суурилсан эрт илрүүлэг эхлээгүй байна.<br><br>1. Эрүүл мэндийн сайдын 2025 оны 05 тушаал тушаалын дагуу нэгдсэн эмнэлгүүдэд нярайн эрт илрүүлгийг 3 төрлийн үзлэг хийж байгаа бөгөөд нярайн түнхний эрт илрүүлэгт 335, нүдний эрт илрүүлэгт 152, зүрний эрт илрүүлэг 152 нярай тус тус хамрагдсан.<br>Тус үзлэгээр түнхний дутуу хөгжил 28 /8,3%/, зүрхний гажиг 1 /0,3%/ илэрснийг эмчилгээ хяналтад авсан.<br>2. Ажлын байрны эрт илрүүлэгт 54 байгууллагын 901 иргэн хамрагдсан.<br>3. Хорт хавдрын эрт илрүүлгийг МҮОНТ, Хаан банк, ХСҮТ-тэй хамтран 6 сард зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | ✓ Нярайн эрт илрүүлэг<br>✓ Сургуульд суурилсан эрт илрүүлэг<br>✓ Ажлын байран дахь эрт илрүүлэг<br>✓ Хавдрын эрт илрүүлэг | | | | **Хэрэгжсэн.** |
| | 3.11.4 | ✓ Үндэсний хэмжээнд эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжиж байгаа 18 арга хэмжээний төлөвлөгөөний й хэрэгжилтийг хангаж ажиллана. | Улсын төсөв 29.985.514 | Зохион байгуулах арга хэмжээний тоо | 95 | -Эрүүл идэвхтэй амьдралын хэв маягийг төлөвшүүлж Эрүүл шүд, Эрүүл настан, идэвхитэй насжилтыг дэмжих, Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, Сэтгэцийн эрүүл мэнд, Жендерт суурилсан болон гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, сэргийлэх, Элэг бүтэн Монгол, Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх зэрэг 18 арга хэмжээнүүдийн хүрээнд 108 арга хэмжээ төлөвлөснөөс эхний хагас жилийн байдлаар 49 арга хэмжээг амжилттай хэрэгжүүлж 45,3% гүйцэтгэлтэй байна. Үүний хүрээнд дараах ажлууд зохион байгуулагдсан байна. Үүнд<br>-Шүд угаалтын аймгийн сумын аварга шалгаруулах тэмцээн<br>-Хүний папиллома вирусийн эсрэг дархлаажуулалтыг нэмэгдүүлэх сургалт<br>-Осол гэмтлээс сэргийлэх “Агшин бүрт анхаарал сэрэмжийг нэмж эрсдлийг бууруулъя” сарын аян<br>-Жендерт суурилсан хүчирхийллээс сэргийлэх 16 хоногийн аян<br>-Хоол, шим тэжээлийн хууль, журам, эрүүл зохистой хооллолтыг дэмжин сурталчилах 7 хоногийн аян<br>-Олон нийтийн эрүүл мэндийн ажилтнаар дамжуулан иргэдэд хүр үйлчлэх |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | -Настны эрүүл мэндийн цогц үнэлгээ, алхалт, сургалт, нөлөөллийн зэрэг үйл ажиллагааны хүрээнд бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд хамтдаа 26 төрлийн 78 удаагийн зорилтот сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж 20772 иргэнийг хамруулсан. **Хэрэгжсэн** |
| | 3.11.5 | Алслагдсан сумдад амны хөндийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг өргөжүүлэн үзлэг оношилгоо, эмчилгээний явуулын баг ажиллуулан урьдчилан сэргийлэх, эмчлэх эрүүлжүүлэх арга хэмжээг санхүүжилтийн хувьд дэмжлэг үзүүлэн ажиллана | Эрүүл мэндийн даатгалын санхүүжилт 108,396,960 | Амны хөндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан хүүхдийн тоо, эрүүлжүүлэлтийн хувь | 8000<br>30%<br>. | Анхан шатны эрүүл мэндийн төвүүдийн шүдний кабинет нь 2026 оны 05 дугаар сард нийт үзлэг 4170 байна. Үүнээс эрэгтэй 1775, эмэгтэй 2348, 0-17 насны 2563 хүүхэд үзлэг эмчилгээнд хамрагдсан. Нийт эмчилгээ 5610, шүд авалт 1033, түрхлэг 575, сувгийн эмчилгээ 2022, бүрэн эрүүлжсэн 1266, урьдчилан сэргийлэх үзлэг, зөвлөгөө авсан 3751 иргэн хамрагдаж, 30.4 хувийг эрүүлжүүлсэн байна. **Хэрэгжсэн** |
| | 3.11.6 | Анхан шатны эрүүл мэндийн байгууллагад халдварт бус өвчин, тэр дундаа зүрх судасны өвчнөөс сэргийлэх, хянах нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний багц МонПЭН болон | Улсын төсөв | МонПЭН болон мобайл технологи ашиглан тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа байдалд хяналт тавьж, шаардлагатай дэмжлэг үзүүлэх, хамрагдсан | Хагас жилд 100 | Эрүүл мэндийн үзлэгт хамрагдаж чаддаггүй алслагдсан, хөдөлгөөнт ба эмзэг бүлгийн хүн амд анхан шатны тусламж үйлчилгээг мобайл технологийг ашиглан халдварт болон халдварт бус өвчний эрт илрүүлэг оношилгоог хийх зорилгоор 2026 оны 05 сарын байдлаар 15 сум, 6 тосгоны эрүүл мэндийн төвд мобайл тусламж, үйлчилгээг зөөврийн ЭХО аппарат болон зүрхний ЭКГ, явуулын дархлаажуулалт, элэгний B, C болон түргэвчилсэн оношлуур, уушгины үйл ажиллагааг хэмжигч спирометр зэрэг багажийн тусламжтай тусламж үйлчилгээг аймгийн хэмжээнд нийт 52 өрх, 136 хүнд хүрч |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | мобайл технологи ашиглан тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа байдалд хяналт тавьж, шаардлагатай дэмжлэг үзүүлэн ажиллана. | | хүний тоо | | үйлчилсэн байна.<br>Зүрх судасны өвчнөөс сэргийлэх, хянах нэн шаардлагатай тусламж үйлчилгээний багц МонПэн төслийг ДЭМБ-ын байгууллагын санхүүжилтээр ЭМЯ, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвтэй хамтран зүрх судасны нэн шаардлагатай тусламж үйлчилгээний багцийн үзлэг оношилгоонд 2087 иргэн хамрагдан оношлогдож, 105 зүрх судасны эрсдэлтэй иргэнийг илрүүлэн, эмчилгээ хяналтад авч ажиллаж байна.<br>**Хэрэгжсэн** |
| | 3.11.7 | Сэтгэцийн эрүүл мэнд, ялангуяа хүүхэд, өсвөр үеийнхэнд сэтгэлзүйн тусламж, үйлчилгээ үзүүлэх, сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, архи, тамхи, утаат болон электрон тамхи, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлийн талаарх мэдлэг олгох, хэрэглээг бууруулах, урьдчилан сэргийлэх болон осол, | Улсын төсөв | Сургалтын тоо<br>Сургалтад хамрагдсан хүний тоо<br>Хамтарч сургалт хийсэн байгууллагын тоо | 20<br>25000<br>5 | Аймгийн эрүүл мэндийн газрын даргаар батлуулсан 2024-2027 онуудад хэрэгжүүлэх “Сэтгэцийн эрүүл мэнд” арга хэмжээний төлөвлөгөөг 4 зорилтын хүрээнд 8 арга хэмжээг төлөвлөн 60 хувийн биелэлттэй ажиллаж байна. Эрүүл мэндийн байгууллагууд ерөнхий боловсролын сургуулийн багш нартай хамтран “Электрон тамхины хэрэглээ”, “Дам тамхидалтын хор уршиг” сэдвээр 24 удаагийн сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулж, өсвөр үеийг ойлгох, нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрүүл хооллох, сэтгэцийн эрүүл мэндийн чиглэлээр 1820 сурагчийг хамруулсан. Бүх шатны эрүүл мэндийн байгууллагуудын эрүүл мэндийн газрын фэйсбүүк, вэйб сайт хуудсаар дамжуулан 5 төрлийн мэдээлэл (Эрүүл мэндийн салбар дахь хүүхэд хамгаалал, Жирэмсэн, хөхүүл ээжүүдийн шим тэжээлийн хэрэглээний зөвлөмж, Харилцан хүндэтгэе, Эрэгтэйчүүдийн эрүүл мэнд, Тамхины хяналтыг эрчимжүүлэх)-ийг 4200 удаа хуваалцаж, 75000 гаруй иргэдийн хандалт авсан үзүүлэлттэй байна.<br>2,3,4 дүгээр сургууль, 1,5-р цэцэрлэгийн сурагч, эцэг эхчүүд, багш ажилчдын нийт 465 хүнд эрүүл |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | гэмтлээс сэргийлэх (ахуйн орчны осол гэмтэл, уналт, автотээврийн гэх мэт)-д анхаарч салбар дундын хамтын ажиллагааг өргөжүүлнэ. | | | | амьдралын хэв маягийг төлөвшүүлэх чиглэлээр танхимын сургалтыг зохион байгуулан ажилласан.<br>2026 оны 1 дүгээр сард “Осол гэмтлийг бууруулъя II” аяныг өрнүүлснээр аймгийн хэмжээнд Цагаан сарын баяр наадмын өмнө осол гэмтлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр олон нийтэд чиглэсэн мэдээлэл, сургалт, нөлөөллийн ажлууд эрчимжиж, танхимын болон иргэдэд хүрсэн мөлхөө сурталчилгааг 3000 гаруй иргэдэд, цахим орчинд 222000 гаруй хүнд хүргэж ажилласнаар түлэгдэлт, осголт, хөлдөлт, зам тээврийн осол гэмтлийн шалтгаант нас баралт бүртгэгдээгүй байна.<br>2026 оны 05 сарын 30-нд Тамхидалтын эсрэг дэлхийн өдрийг тэмдэглэн өнгөрүүлж, 300 гаруй өсвөр насны хүүхэд, эцэг эх асран хамгаалагчдад тамхи, электрон тамхи, түүний хор нөлөө, эрүүл мэндийн эрсдэлийг ойлгуулан таниулах нөлөөллийн өдөрлөг амжилттай зохион байгууллаа.<br>**Хэрэгжсэн** |
| | 3.11.8 | Хүн амын дунд зонхилон тохиолдож байгаа сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдварт өвчнийг тандах, илрүүлэх, урьдчилан сэргийлэх үзлэгт зорилтот бүлгийг хамруулах арга хэмжээг төрийн | 22,338,800 | Сургалтад хамрагдсан хүний тоо<br><br>Зорилтот бүлгийн эрт илрүүлэгт хамрагдсан хүний тоо | 3500<br><br>2700 | Тайлангийн хугацаанд бэлгийн замаар дамжих халдвар 10,000 хүн амд нийт өвчлөл-104, трихомониаз-3,9, заг хүйтэн-1,6, тэмбүү-5.4 промил байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал тэмбүү-4.2, трихомониаз-1,0, промилоор өссөн бол заг хүйтэн-0,8 промилоор буурсан үзүүлэлттэй байна. Өвчтэй илэрсэн иргэд болон хавьтлыг эмчилгээнд бүрэн хамруулан ажиллаж байна.<br>Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад бэлгийн ариун цэвэр, бэлгийн замаар дамжих халдварт өвчний талаарх сургалтыг зохион байгуулж 250 сурагчдыг хамруулсан. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | болон төрийн бус байгууллага, ажил олгогчидтой хамтран зохион байгуулж, халдвартай иргэдийг эмчилгээнд бүрэн хамруулж, эмчилгээнд хамрагдалт, эмчилгээний үр дүнд улирал бүр хянана. | | | | ДОХ болон Сүрьеэгийн хөтөлбөрийн олон улсын үнэлгээний баг Сэлэнгэ аймгийн Эрүүл мэндийн газар дээр ажиллаж, мэргэжил арга зүйгээр ханган ажилласан. Дэлхийн сүрьеэтэй тэмцэх өдрийг “УЛС ОРНЫ МАНЛАЙЛАЛ, ИРГЭДИЙН ХҮЧТЭЙ ОРОЛЦООТОЙГООР БИД СҮРЬЕЭГ УСТГАЖ ЧАДНА! “уриан дор удирдамж боловсруулан сургалт, мэдээлэл, сурталчилгааны ажлыг зохион байгуулж нийт 4500 гаруй иргэдийг хамруулж, сүрьеэ өвчний халдвар дамжих зам, шинж тэмдэг, урьдчилан сэргийлэх арга хэмжээ, эмчилгээний талаарх мэдлэгийг олгосон.<br>ХӨСҮТ-ийн дэмжлэгтэйгээр анхан шатны 10 эрүүл мэндийн байгууллагад сүрьеэгийн тусламж үйлчилгээнд дэмжлэгт хяналт үнэлгээ хийж зөвлөмж мэдээллийг хүргүүллээ. Хүн амын дунд сүрьеэгийн эрт илрүүлэг үзлэгийг зохион байгуулж далд хэлбэрийн сүрьеэг илрүүлэх зорилгоор Монголын сумын эмч мэргэжилтний холбоотой хамтран эрсдэлт бүлгийн иргэдэд чиглэсэн "Хаалганаас хаалганд" сүрьеэгийн эрт илрүүлгийн үзлэгийг Мандал, Түнхэл, Цагааннуур, Зүүнбүрэн, Жавхлант, Хүдэр, Шаамар, Алтанбулаг, Сайхан, Орхонтуул, сум, тосгонд зохион байгуулж нийт-1774 иргэнийг хамруулахад сүрьеэтэй байж болзошгүй тохиолдол-108, Genexpert MTB/RIF шинжилгээнд хамрагдсан хүний тоо-42, үүнээс 23 хүн шинжилгээнд хамрагдсан бол нян судлалын шинжилгээгээр 6 шинэ тохиолдлыг илрүүлсэн.<br><br>**Хэрэгжсэн** |
| | 3.11.9 | Дархлаажуулалтын ач холбогдлыг төрийн болон төрийн | Улсын төсөв | Товлолын | . | Монгол улсын Дархлаажуулалтын тухай хуулийн 10 зүйл, МУЗГ-ын 2023 оны 473 дугаар тогтоолд заасан дархлаажуулалтын үндэсний товлолд |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | бус байгууллага, аж ахуйн нэгжтэй хамтран иргэдэд сургуульд суурилсан дархлаажуулалтыг зохион байгуулахад эрүүл мэндийн байгууллага болон боловсролын байгууллага хамтран ажиллахад дэмжлэг үзүүлэн дархлаажуулалтын хамралтыг орон нутгийн түвшинд нэмэгдүүлнэ. | | дархлаажуулалтын хамралтын хувь<br>Папиллома вирусийн дархлаажуулалтын хамралтын хувь<br>Сургалтад хамрагдсан хүний тоо | 95<br>70%<br>1000 | заасан заавал хийгдэх дархлаажуулалтаар 15 төрлийн халдварт өвчнөөс 9 төрлийн вакциныг хийж байгаа ба дархлаажуулалтын хамралт **95-98%-**иас дээш байна.<br>Аймгийн Засаг даргын захирамжийн дагуу томилогдсон ажлын хэсэг сумдад "Хүний папиллома вирусийн халдварын эсрэг вакцин болон товлолын дархлаажуулалтын ач холбогдлын талаарх сургалтыг **105** эрүүл мэндийн байгууллагын ажилтан, **102** багш ажилчид, **300** гаруй зорилтот бүлгийн хүүхдүүд, **1800** гаруй асран хамгаалагч иргэдэд хийж, анхан шатны эрүүл мэндийн байгууллагын дархлаажуулалтын хүйтэн хэлхээний дэмжлэгт хяналтыг хийж ажилласан.<br>2026 онд 4 дүгээр сард сургуульд суурилсан хүний папиллома вирусийн эсрэг дархлаажуулалтад зорилтот бүлгийн 11 настай 1918 хүүхэд хамрагдахаас 1705 хүүхэд хамрагдаж, хамрагдалт **88,9**%-тай байна.<br>**Хэрэгжсэн** |
| | 3.11.10 | Эхийн сүүгээр хооллолтыг дэмжих, нялх, балчир хүүхдийг эрүүл аюулгүй хүнсээр тасралтгүй хангах, хүнсний чанар, аюулгүй байдлын хяналтыг хэрэгжүүлэх хүрээнд Нялх балчир хүүхдийн хүнсний тухай хуулийн | Улсын төсөв | Хуулийн хэрэгжилтийг хангаж, сургалт нөлөөллийн арга хэмжээ болон дэмжлэгт хяналт үнэлгээг хийж ажиллах | Нялх балчир хүүхдийн хүнсний тухай хууль | Сэлэнгэ аймгийн Сүхбаатар, Мандал сумдын телевиз, Цахим телевизээр дамжуулан эхийн сүүний ач холбогдол, нялх балчир хүүхдийн хооллолтын зөвлөмж, шторкуудыг олон нийтэд түгээж ажилласан.<br>Аймгийн төвд байрлах мэдээллийн самбар, эрүүл мэндийн байгууллагуудын хананд жирэмсний аюултай шинж, эхийн сүүгээр хооллолтын ач тус, нялх хүүхдийг ахуйн болон бусад осол гэмтлээс сэргийлэх ханын самбаруудыг ил тод байршуулан, мөлхөө сурталчилгааг хийж олон нийтэд сурталчилан бүх шатны Эрүүл мэндийн байгууллагууд Нийгмийн эрүүл мэндийн төвийн бэлтгэсэн зөвлөмж мэдээллийг цахим орчинд хуваалцаж, |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | биелэлтийг хангаж, хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж ажилллана. | | | | 1500 гаруй таалагдсан сэтгэгдэл, 69000 гаруй хүнд хүрсэн үзүүлэлттэй байна.<br>Эрүүл мэндийн яамны 2026 оны 01 дүгээр сарын 09-ны өдрийн 4/129 дүгээр, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн 2026 оны 01 дүгээр сарын 09-ны өдрийн 3-1/21 дүгээр “Сэрэмжлүүлэг мэдээлэл хүргэх тухай” албан бичгийн дагуу Сэлэнгэ аймгийн 17 сум, 6 тосгон, 5 өрхийн эрүүл мэндийн төв, нийт 28 нэгжид мэдээллийг шуурхай хүргэн, Эрүүл мэндийн газрын вэбсайт, сум, тосгоны эрүүл мэндийн байгууллагуудын пэйж хуудсуудад хүүхдийн аюулгүй байдлыг хамгаалах зорилгоор, тодорхой цувралын дугаар бүхий нялхсын сүүн тэжээлийн талаар олон нийтэд сэрэмжлүүлэг, хүргэж ажилласан.<br>Аймгийн Нэгдсэн эмнэлэг, Эмнэх баг Өрхийн ЭМТ, Номгон ЭМТ зэрэг ЭМБ-ууд эх хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлсэн. Мандал сумын нэгдсэн эмнэлэгт ээжүүдийн сургалт өдөрлөг зохион байгуулж, 57 жирэмсэн эхчүүд, Түнхэл тосгоны төвөөс алслагдсан 3 хэсгийн 26 жирэмсэн, төрсөн эхчүүдийг сургалтад хамруулан мэдээлэл өгч ажилласан. Нөхөн үржихүйн насны -24, өсвөр насны 19 эмэгтэйд мөн зөвлөгөө мэдээлэл хүргэж ажилласан.<br><br>2025-2026 онд Эхийн сүүгээр хооллолтыг дэмжих үндэсний сургагч багшаар 3 эмч, эмнэлгийн мэргэжилтэн бэлтгэгдсэн байна.<br>**Хэрэгжсэн.** |
| | 3.11.11 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэн эрүүл мэндийн | Орон нутгийн төсөв | Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тусламж үйлчилгээний | 5 эрүүл мэндийн байгууллага | Сэлэнгэ аймгийн эрүүл мэндийн салбарын хэмжээнд 4 эрүүл мэндийн байгууллага хөгжлийн бэрхшээлтэй иргэнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах нөхцлийг бүрдүүлж, |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | тусламж, үйлчилгээг авах дэд бүтцийг сайжруулан, тэдний мэдээлэл авах эрхийг хангах зорилгоор шат баррель үсэг, зам дуут санамжийг нэвтрүүлэлтэд хяналт тавьж ажиллана. | 8.165.000 төг | чанар хүртээмжийг нэмэгдүүлсэн эрүүл мэндийн байгууллагын тоо | | налуу зам, таяг, тэргэнцэр, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зориулсан ариун цэврийн өрөө, баррель үсэг, дуугүй хөтөч, хананд барьж явах бариул, хэвтэн эмчлүүлж байгаа иргэдэд толгой угаах цомог, хоол идэх цомог, 00 өрөө, дуут хонх зэргийг шинээр байгуулан, гэрээр эргэх иж бүрэн цомгийн бүрдэлтэй болж 8.165.000 төгрөг зарцуулсан байна.<br>Ингэснээр хөгжлийн бэрхшээлтэй иргэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлэн ажилласнаар, эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмж нэмэгдсэн байна.<br>**Хэрэгжсэн** |
| | 3.11.12 | Эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг хангаг эрүүл мэндийн байгууллагыг сайжруулсан ариун цэврийн байгууламжтай болоход дэмжлэг үзүүлж, 1-2 сумын эрүүл мэндийн төвийн ариун цэврийн байгууламжийг стандартын дагуу шинэчлэн байгуулна. | 5.530.000 | Ариун цэврийн байгууламжтай болсон эрүүл мэндийн төв | 1 | Сэлэнгэ аймгийн Эрүүл мэндийн газар салбарын хэмжээнд “Нүхэн жорлонг халах аян” өрнүүлж, анхан болон лавлагаа шатны бүх эмнэлгүүд орчин үеийн шаардлага хангасан ариун цэврийн боловсон байгууламжтай болж чадсан.<br><br>Баруунбүрэн сумын эрүүл мэндийн төв нь ариун цэврийн байгууламжийг шинэчлэн эрэгтэй, эмэгтэй 00-н өрөөг тусад нь болгон стандартын дагуу шинэчилсэн.<br><br>Жавхлант сумын эрүүл мэндийн төв хэвтэн эмчлүүлэгч болон халдвартын ариун цэврийн өрөөний хана, таазыг хулсан хавтан болгож их засвар хийсэн ба амбулатори, хэвтэн эмчлүүлэх хэсгийн ариун цэврийн өрөөнд хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан бариул байрлуулсан.<br>**Хэрэгжсэн** |
| | 3.11.13 | Алслагдсан эрүүл мэндийн төвүүдэд | Улсын төсөв | Нарны болон гүний сэргээгдэх | 1 сумын эрүүл | Дархан, Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ компанийн хэрэгжүүлсэн төслийн хүрээнд |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд нарны болон газрын гүний сэргээгдэх эрчим хүчийг ашиглан түүхий нүүрсний хэрэглээг 5-8 сумын эрүүл мэндийн төвд зогсооно. | | эрчим хүч ашигласан байгууллагын тоо | мэндийн төв | Цагааннуур сум нарны эрчим хүчээр цахилгаан гаргаж, эрчим хүчээр хангагдсаны үр дүнд цахилгааны сааталгүй ажиллаж байна.<br><br>**Хэрэгжсэн** |
| | 3.11.14. | Усны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.4, Эрүүл ахуйн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 4.1.5, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дэх хэсэгт заасныг үндэслэн харьяалах нутаг дэвсгэрийнхээ хүн амыг чанар, аюулгүй байдлын шаардлага хангасан ундны усаар тогтвортой, хүртээмжтэй хангах, ус хангамж, ариун цэврийн байгууламжийн | Орон нутгийн төсөв | | | Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Эрүүл ахуйн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 4.1.4, 4.1.5, 11 дүгээр зүйлийн 11.1.1, 11.1.3, Усны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4, 12.1.5, Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.5, 17 дугаар зүйлийн 17.4 дэх заалт, Эрүүл мэндийн сайд, Барилга, хот байгуулалтын сайдын хамтарсан 2017 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн А/149/78 дугаар тушаалаар батлагдсан "Ус хангамж, ариун цэврийн байгууламжийн сүлжээнд эрсдэлийн үнэлгээ хийх заавар"-ыг тус тус үндэслэн "Ундны усны аюулгүй байдлын төлөвлөгөө боловсруулах, хэрэгжилтийг хангах баг байгуулах тухай" захирамжийн төслийг 2 хавсралттай боловсруулж аймгийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэн 2025 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн А/427 дугаар захирамжийг батлуулсан. Тус захирамжийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор тайлангийн хугацаанд |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | аюулгүй байдлын төлөвлөгөөг хэрэгжүүлнэ. | | | | “Сэлэнгэ цэнгэг ус” ОНӨААТҮГ-ын итгэмжлэгдсэн лаборатори, Стандарт хэмжил зүйн хэлтсийн итгэмжлэгдсэн лабораторитой хамтран 11 сумын 51 цэгээс 102 дээжийг авч шинжилгээнд хамруулж, эх үүсвэрт эрсдэлийн үнэлгээг хийсэн. Шинжилгээт хяналт үргэлжилж байгаа тул 3 дугаар улиралд эцэслэгдэж төслийг танилцуулна. **Хэрэгжсэн** |
| | 3.11.15 | Эрүүл мэндийн байгууллагыг уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй, цахилгааны тасралтгүй эх үүсвэрээр хангах, цахилгаан эрчим хүчний догогдлоос эмнэлгийн тоног төхөөрөмж гэмтэх, цахилгааны богино холбоо үүсэх эрсдэлээс сэргийлж, дотоод хяналтыг тогтмолжуулж, цахилгааны нөөц эх үүсвэрийн бэлэн байдлыг хангаж ажиллана. | Улс болон ОУБайгуулл ага | Цахилгааны эх үүсвэрээр хангагдсан эрүүл мэндийн байгууллагын тоо | 28 | Аймгийн нэгдсэн эмнэлэг, Алтанбулаг, Хэрх, Цагааннуур сумын эрүүл мэндийн байгууллагууд нь нарны болон цахилгааны хосолсон системд холбогдон эмнэлгийнхээ 25-75 хувийг эрчим хүчээр хангаж ажиллаж байна. Бусад эрүүл мэндийн байгууллагууд нь тог тасарсан тохиолдолд цахилгаан мотор ашиглаж б Аймгийн нэгдсэн эмнэлэг, мандал сумын нэгдсэн эмнэлэг, анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын улсын төсвийн болон Олон улсын байгууллагын хөрөнгөөр цахилгааны эх үүсгүүрээр 100% хангагдсан. **Хэрэгжсэн** |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | 3.11.16 | Эрүүл ахуйн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3-т “Барилга байгууламж барих газрын байршил тогтоох, барилгын зураг төсөл зохиох, барилга барих, ашиглалтад оруулах, өргөтгөх, зориулалтыг нь өөрчлөхөд эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар эрүүл ахуйн дүгнэлт гаргуулна” гэж заасны дагуу газар олгохтой холбоотой дүрэм, журамд өөрчлөлт оруулах замаар барилга байгууламж барих газрын байршил тогтооход эрүүл ахуйн дүгнэлт гаргуулж байх нөхцөлийг бүрдүүлэхэд анхааран ажиллана. | Улсын төсөв | | | Тайлангийн хугацаанд нийт 24 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын загвар зураг төсөл болон, ажлын зураг төсөлд ирүүлсэн хүсэлтийн хүрээнд холбогдох хууль тогтоомж, тэдгээртэй нийцүүлэн гаргасан дүрэм, журам, стандартын хэрэгжилтийн байдалд урьдчилан сэргийлэх хяналт хийж зураг төслийг мэргэжлийн байгууллагаар баталгажуулаагүй барилгын ажил эхлүүлсэн, барьж дууссаны дараа зураг төсөл төсөл хянуулахаар хүсэлт ирүүлсэн гэх 3 аж ахуйн нэгжид тус бүр 2500 нэгж буюу 7.500.000 төгрөгийн шийтгэлийн арга хэмжээг авч 100% барагдуулж ажилласан.<br>Монгол Улсын Эрүүл ахуйн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3-т тусгагдсан “Барилга байгууламж барих газрын байршил тогтоох, барилгын зураг төсөл зохиох, барилга барих, ашиглалтад оруулах, өргөтгөх, зориулалтыг нь өөрчлөхөд эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар эрүүл ахуйн дүгнэлт гаргуулна” заалтын дагуу Эрүүл мэндийн газрын Хяналт шалгалтын хэлтсийн эрх бүхий албан тушаалтан зураг төслийн явцад хяналт тавьж ажилладаг, газар олголтын явцад хөрсний бохирдлын түвшин болон эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн дэглэм зэрэгт хяналт тавьж тус хуулийн заалтын хэрэгжилтийг 100% хангуулах боломжгүй, орон нутгийн удирдлагын түвшинд жил бүр танилцуулгад асуудлыг тусгаж байгаа болно.<br>**Хэрэгжсэн** |
| **3.12. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар** | | | | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | 3.12.1 | Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд "Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага" MNS 7014:2023 стандартын үнэлгээ хийж үнэлгээнээс гарсан дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж дэмжлэг үзүүлж ажиллана | Улсын төсөв | Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд "Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага" MNS7014:2023 стандартыг эрүүл мэндийн байгууллага бүрд хэвшүүлж, хэрэгжилтийг хангасан байх | "Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага" MNS7014:2023 стандартыг бүх шатны эрүүл мэндийн байгууллагудад хяналт тавьж, үр дүнг тооцсон байна. | Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор Эрүүл мэндийн газрын даргын 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн А/04 дүгээр тушаалаар дэмжлэгт хяналт, үнэлгээг Орхон, Баянгол, Сайхан, Ерөө, Түшиг, Цагааннуур сум, Хэрх, Түнхэл, Бугант тосгоны ЭМТ дээр хийж "Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих MNS 7014:2023 стандарт"-ын хэрэгжилтийг хянан, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах 2026 оны ажлын төлөвлөгөөг боловсруулан бүх шатны эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлсэн.<br>Мөн Эрүүл мэндийн сайд, аймгийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээний эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлтийг сайжруулах дэмжлэг хяналтыг 2026 оны 04 дүгээр сараас 05 дугаар сарын хооронд Цагааннуур, Ерөө, Сайхан, Мандал бүсийн эрүүл мэндийн байгууллагуудад хуваарийн дагуу хийж, эрүүл мэндийн байгууллагуудад хэрэгжиж буй хууль, стандарт, тушаал, журам зааврыг танилцуулах, хэрэгжүүлэх тал дээр зөвлөн туслан ажиллаж байна.<br>**Хэрэгжсэн** |
| | 3.12.2 | Анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэгч өрх, сумын эрүүл мэндийн төвөөс үзүүлэх гэрийн эргэлт, архаг өвчний хяналт тавьж, орон нутагт түр оршин суугч (отор) | Улсын төсөв | Орон нутагт түр оршин суугч, явуулын иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чирэгдэлгүй үзүүлсэн байх, хамрагдсан иргэдийн тоо | Эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх шаардлагатай иргэн бүрд чирэгдэлгүй үйлчилгээ үзүүлж, | 2026 оны 05 сарын байдлаар эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний нийт үзлэгийн 38,6 хувийг урьдчилан сэргийлэх үзлэг, 7,7 хувийг гэрийн эргэлт, диспансерын хяналт 9,9 хувийг тус тус үзүүлсэн байна.<br>Аймгийн хэмжээнд өөр аймаг буюу аймаг дотроо отор нүүдлээр явж байгаа 34 өрхийн 73 иргэн байгаагаас 0-5 насны 6 хүүхэд, архаг суурь авчтэй 1 иргэн байна.<br>Нийт алслагдсан малчин 1002 өрхийн 2219 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | явуулын иргэдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг харьяалал харгалзахгүй түргэн шуурхай үзүүлнэ. | | | тусламж үйлчилгээний чанар, хүртээмж нэмэгдүүлсэн байна. | иргэнд эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлж, үүнээс жирэмсэн 5, 0-5 насны 113, хөгжлийн бэрхшээлтэй 47, архаг суурь өвчтэй 89, ахмад настан 147 иргэнд 2-3 төрлийн нарийн мэргэжлийн эмчийн үзлэг болон явуулын эмийн сангийн тусламж үйлчилгээг үзүүлсэн байна. **Хэрэгжсэн** |
| | 3.12.3 | Жирэмсний эрт үеийн хяналтын хамралтыг нэмэгдүүлэн жирэмсэн үеийн гурвалсан халдвар (ХДХВ, тэмбүү, гепатитын В, С, вирус)-ын илрүүлэг шинжилгээний хамрагдалт, тэмбүүтэй жирэмсэн эмэгтэйн эмчилгээ, эмчилгээний дараах хяналт, бэлгийн хавьтагчийн илрүүлэлт, оношилгоо, эмчилгээний байдалд байнга хяналт тавьж төрөлхийн тэмбүүгийн тохиолдол гаргахгүй | Улсын төсөв | - Жирэмсний эрт үеийн хяналтыг 90 хувьд хүргэх, -Жирэмсэн үеийн гурвалсан халдвар (ХДХВ, ДОХ, гепатитын В, С вирус)-ын илрүүлэг шинжилгээнд бүрэн хамруулах, -Тэмбүү илэрсэн жирэмсэн эмэгтэй, хавьтагчийн хамт эмчилгээ, хяналтад бүрэн хамруулж, төрөлхийн тэмбүүгийн тохиолдол гаргахгүй байх. | Жирэмсний эрт үеийн хяналт 90-д хүргэж, жирэмсэн үеийн гурвалсан шинжилгээнд шинээр хяналтанд орсон бүх жирэмсэнг хамруулан, тэмбүүтэй илэрсэн жирэмсэн эмэгтэйг, хавьтагчийн хамт эмчилгээ хяналтад бүрэн хамруулснаар гарч болох эрсдэлээс сэргийлж, тусламж үйлчилгээн | Сэлэнгэ аймагт 2026 оны эхний 5 сарын байдлаар шинээр 501 жирэмсэн хяналтад орсны 93,0 хувийг жирэмсний эхний 3 сарын дотор хяналтад авсан байна.<br>Нийт жирэмсний хяналтад орсон эмэгтэйчүүдийг 99,8 хувь цусны шинжилгээнд, тэмбүү 99.4, ДОХ 99.4, трихомониз 91, заг хүйтэн илрүүлэх шинжилгээнд 89.6 хувийг тус тус хамруулсан байна. Үүнээс анхан болон давтан шинжилгээгээр цус багадалттай 5 жирэмсэн, заг хүйтэн илрээгүй, трихомониазтай 7, тэмбүүтэй 3 жирэмсэн, хавьтагч нартай нь илрүүлж эмчилснээр төрөлхийн тэмбүүгийн тохиолдол бүртгэгдээгүй. **Хэрэгжсэн** |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | ажиллана. | | | ий чанар дээшилсэн байна. | |
| | 3.12.4 | Өрхийн эрүүл мэндийн төвтэй байгуулсан гэрээний үүргээ биелүүлж үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажиллана. | Улсын төсөв | Гэрээний биелэлтийн дагуу үйл ажиллагааг дэмжин ажиллаж, хэрэгжилтэд хяналт тавьсан байх | Гэрээний биелэлтийг хагас, бүтэн жилээр дүгнэсэн байна | Өрхийн эмнэлгүүдтэй хамтран ажиллах гурвалсан гэрээг 2026 оны 02 дугаар сард байгуулж, хагас жилийн үнэлгээг гэрээнд заасан хугацаанд хийхээр төлөвлөн ажиллаж байна.<br>**Хэрэгжсэн** |
| | 3.12.5 | Өрх, сумын эрүүл мэндийн төвд 9 сар, 18 сар, 36 сартай хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэг тогтмол зохион байгуулж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах, хөдөлгөөн засах тусламж, үйлчилгээг өргөжүүлж энэ чиглэлийн тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа эрүүл мэндийн байгууллагыг дэмжиж | Улсын төсөв | 9, 18, 36 сартай хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэгийн хамрагдалтыг нэмэгдүүлж, хамрагдсан хүүхдийн тоо, онош тодруулсан хүүхдийн тоо | Эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэгийн хамрагдалт нэмэгдэн, хөгжлийн хоцрогдолтой хүүхдийг дараагийн шатны эмчилгээ, хяналтад эрт оруулж, хөгжлийн дэмжлэгийн үйлчилгээнд хамрагдсан байна. | Эрүүл мэнд, Боловсрол, Хөдөлмөр нийгмийн хамгааллын А/220, А/475, А/812 дугаар хамтарсан тушаалын хэрэгжилтийг ханган зорилгоор 9, 18, 36 сартай хүүхдийн эрүүл мэнд хөгжлийн цогц үзлэгийг үе шаттайгаар зохион байгуулж, сум, тосгоны болон өрхийн эрүүл мэндийн төвүүдээс сар бүрийн 05-ний өдөр эрт илрүүлэг үзлэгийн талаарх мэдээ тайланг нэгтгэн авч, үзлэгийн хувийг нэмэгдүүлэн ажиллаж байна.<br>2026 оны байдлаар 05 дугаар сарын байдлаар 9, 18, 36 сартай хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэгт нийт 1012 хүүхэд хамрагдаж, үүнээс хөгжлийн хоцрогдол болон суурь өвчин илэрсэн 29 хүүхэд байгаа бөгөөд тухай бүр дараачийн шатлалд 4 хүүхдийг илгээсэн.<br>**Хэрэгжсэн** |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | ажиллана | | | | |
| | 3.12.6 | Жирэмсний эрт үеийн хяналтын хамралтыг нэмэгдүүлэн жирэмсэн үеийн гурвалсан халдвар (ХДХВ, тэмбүү, гепатитын В, С, вирус)-ын илрүүлэг шинжилгээний хамрагдалт, тэмбүүтэй жирэмсэн эмэгтэйн эмчилгээ, эмчилгээний дараах хяналт, бэлгийн хавьтагчийн илрүүлэлт, оношилгоо, эмчилгээний байдалд байнга хяналт тавьж төрөлхийн тэмбүүгийн тохиолдол гаргахгүй ажиллана. | Улсын төсөв | - Жирэмсний эрт үеийн хяналтыг 90 хувьд хүргэх,<br>-Жирэмсэн үеийн гурвалсан халдвар (ХДХВ, ДОХ, гепатитын В, С вирус)-ын илрүүлэг шинжилгээнд бүрэн хамруулах,<br>-Тэмбүү илэрсэн жирэмсэн эмэгтэй, хавьтагчийн хамт эмчилгээ, хяналтад бүрэн хамруулж, төрөлхийн тэмбүүгийн тохиолдол гаргахгүй байх. | Жирэмсний эрт үеийн хяналт 90-д хүргэж, жирэмсэн үеийн гурвалсан шинжилгээнд шинээр хяналтанд орсон бүх жирэмсэнг хамруулан, тэмбүүтэй илэрсэн жирэмсэн эмэгтэйг, хавьтагчийн хамт эмчилгээ хяналтад бүрэн хамруулснаар гарч болох эрсдэлээс сэргийлж, тусламж үйлчилгээний чанар дээшилсэн байна. | Сэлэнгэ аймагт 2026 оны эхний 5 сарын байдлаар шинээр 501 жирэмсэн хяналтад орсны 93,0 хувийг жирэмсний эхний 3 сарын дотор хяналтад авсан байна.<br>Нийт жирэмсний хяналтад орсон эмэгтэйчүүдийг 99,8 хувь цусны шинжилгээнд, тэмбүү 99.4, ДОХ 99.4, трихомониз 91, заг хүйтэн илрүүлэх шинжилгээнд 89.6 хувийг тус тус хамруулсан байна. Үүнээс анхан болон давтан шинжилгээгээр цус багадалттай 5 жирэмсэн, заг хүйтэн илрээгүй, трихомониазтай 7, тэмбүүтэй 3 жирэмсэн, хавьтагч нартай нь илрүүлж эмчилснээр төрөлхийн тэмбүүгийн тохиолдол бүртгэгдээгүй.<br>**Хэрэгжсэн** |
| | 3.12.7 | Жирэмсэн эмэгтэйн амь насанд ноцтой | Улсын төсөв | Ноцтой хүндрэлд дэмжлэг | Жирэмсэн эмэгтэйн амь насанд | Жирэмсэн эмэгтэйн амь насанд ноцтой хүндрэл одоогоор бүртгэгдээгүй байна.<br>**Хэрэгжсэн** |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | хүндрэл гарч зайлшгүй тээвэрлэх шаардлага үүссэн тохиолдолд онгоц болон бусад тээврийн хэрэгслийн зардлыг Засаг даргын нөөц хөрөнгөөс гарган дэмжлэг үзүүлнэ. | | үзүүлсэн тоо | ноцтой хүндрэл гарч зайлшгүй тээвэрлэх шаардлага үүссэн тохиолдолд дэмжлэг үзүүлсэн байна. | |
| | 3.12.8 | Эх, нялхас, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, ялангуяа сэргийлж болох эндэгдлийг тууштай бууруулах чиглэлээр тэгш, хүртээмжтэй, чанартай тусламж, үйлчилгээг орон нутгийн түвшинд зохион байгуулж, эх, хүүхдийн эндэгдэлд судалгаа хийж, хариу арга хэмжээ хэрэгжүүлэн үр дүнг тооцон ажиллана. | Улсын төсөв | Эхийн эндэгдэл гаргахгүй байх, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг өмнөх оны 16.8 промиллээс бууруулсан байх | Сэргийлж болох эхийн эндэгдэл, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг бууруулж, тусламж үйлчилгээний чанар хүртээмж нэмэгдэн, эмч, эмнэлгийн мэргэжилтний мэдлэг, ур чадвар дээшилсэн байна. | Улсын хэмжээнд 2026 оны 05 сарын байдлаар эхийн эндэгдлийн 2 тохиолдол бүртгэгдэж, 100.000 амьд төрөлтөд 11.5 ногдож байгаа ба манай аймаг 2026 онд эхийн эндэгдэл бүртгэгдээгүй байна.<br>Сэлэнгэ аймгийн хэмжээнд 2026 оны 5 дугаар сарын байдлаар 501 жирэмсэн эх хяналтад байгаа бөгөөд тэдгээрийн шилжилт хөдөлгөөн болон шинжилгээний дүнд шинжилгээ хийснээр хяналтын чанар 93.0%-д хүргэсэн. Мөн 0-1 насны 1360 хүүхдийн шилжилт хөдөлгөөнийг эргэн нягталснаар гэрийн эргэлт 82%-д хүрч өссөн үзүүлэлттэй байна.<br>Эх, нялхас, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл гаргахаас сэргийлж, жирэмсний хяналтыг сайжруулах зорилгоор 2025 оны үйл ажиллагаагаар жирэмсний хяналт, эх барихын тусламж үйлчилгээ хангалтгүй байсан эрүүл мэндийн байгууллагуудад Эрүүл мэндийн газрын даргын 2026 оны А/04 тушаалаар баталсан удирдамжийн дагуу дэмжлэгт хяналт үнэлгээг хийн, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах 7 зорилт 24 заалт бүхий үйл ажиллагааг хэрэгжүүлэх ажлын |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төлөвлөгөө, мөн эрүүл мэндийн салбарын хэмжээнд “Эх хүүхдийн эрүүл мэндийг дэмжих жил” болгон зарласан А/09 тушаалын дагуу эх барихын тусламж үйлчилгээг сайжруулах 5 зорилт, 24 заалт бүхий 2026 оны ажлын төлөвлөгөөг тус тус батлуулан бүх шатны эрүүл мэндийн байгуулагуудад хүргүүлэн хэрэгжүүлэн ажиллаж байна.<br>Эхийн эндэгдлээс сэргийлэх, бууруулах чиглэлээр Эрүүл мэндийн газрын даргын баталсан удирдамжийн дагуу анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудад нөхөн үржихүй, эх, хүүхдийн тусламж үйлчилгээний чиглэлээр дэмжлэгт хяналт үнэлгээг хийж, ажил сайжруулах зөвлөн туслах үйлчилгээ, чиглэл өгөн ажилласан.<br>Анхан шатны бүх эрүүл мэндийн байгууллагуудад долоо хоног бүрийн 4 дэх өдрийн цаг үеийн мэдээллийн цагаар эхний эндэгдэл, ноцтой хүндрэл, 5 хүртэлх хүүхдийн эндэгдлийн чиглэлээр анхааруулах мэдээллийг цахимаар өгч ажилласан. Мөн Эх Хүүхдийн Эрүүл Мэндийн Үндэсний Төвийн Тандалт Судалгааны Албанаас зохион байгуулдаг “Эхийн эндэгдэл, ноцтой хүндрэл”-ийн цахим хуралд холбогдох эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг тасралтгүй хамруулж байна.<br>5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл манай аймгийн хувьд 3 тохиолдол бүртгэгдэж 1000 амьд төрөлтөд 8.2 байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 12.8 промиллоор буурсан үзүүлэлттэй байна.<br>Тус эндэгдлүүдээс эмнэлэг болон эмнэлгийн бус нөхцөлд эндсэн 3 тохиолдлыг магадлан хэлэлцэх хурлыг аймгийн Нэгдсэн эмнэлэг, Мандал сумын Нэгдсэн эмнэлэг 5 хүртэлх насны |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хүүхдийн эндэгдэл хэлэлцэх хурлыг холбогдох эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулж, эндэгдэлд судалгаа хийж, бууруулах чиглэлээр ажлыг зохион байгуулан ажилласан.<br>Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хэлтсийн цаг үеийн байдалтай холбоотой мэдээллийг шуурхай хүргэх хуваарийн дагуу "Жирэмсэн эх, хүүхдийн тусламж үйлчилгээ" сэдвээр 6 удаагийн цахим хурлыг зохион байгууласан.<br>5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг бууруулах зорилгоор Google sheet үүсгэж 9, 18, 36 сартай хүүхдийн хоцрогдлыг үнэлэх сар бүр илгээдэг тайлан, 0-1 насны хүүхэд, 1-5 хүртэлх насны хүүхэд, 6-19 насны хүүхдийн гэрийн эргэлт, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн судалгааг цахим хэлбэрт шилжүүлэн, тогтмол хяналт тавьж байна.<br>Эх, хүүхдийн эндэгдлээс сэргийлэх, бууруулах чиглэлээр Эрүүл мэндийн газрын даргын баталсан удирдамжийн дагуу анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудад нөхөн үржихүй, эх, хүүхдийн тусламж үйлчилгээний чиглэлээр дэмжлэгт хяналт үнэлгээг хийж, ажил сайжруулах зөвлөн туслах үйлчилгээ, чиглэл өгөн ажилласан.<br>**Хэрэгжсэн** |
| | 3.12.9 | Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар аюулгүй байдал, эрсдэлийн удирдлагын | | Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдварын сэргийлэлт, аюулгүй байдлыг хангах дэмжлэгт | Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдварын сэргийлэлт, аюулгүй байдлыг хангах | Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор Эрүүл мэндийн газрын даргын 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн А/04 дүгээр тушаалаар дэмжлэгт хяналт, үнэлгээг Орхон, Баянгол, Сайхан, Ерөө, Түшиг, Цагааннуур сум, Хэрх, Түнхэл, Бугант тосгоны ЭМТ дээр хийж эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмж, халдварын сэргийлэлт, аюулгүй |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | тогтолцоог хөгжүүлэн дэмжиж эмнэлгийн тусламж, үйлчилгээнтэй холбоотой халдвараас сэргийлэх, тандалт судалгаа хийх зэрэг өвчтөний аюулгүй байдлыг хамгаалахад чиглэсэн арга хэмжээний тасралтгүй байдалд хяналт тавьж ажиллана | | хамрагдсан байгууллагын тоо | дэмжлэгт хамрагдсан аар эмнэлгийн тусламж, үйлчилгээн ий чанар, аюулгүй байдлыг сайжирсан байна. | байдлыг хангах үйл ажиллагааг сайжруулах 2026 оны ажлын төлөвлөгөөг боловсруулан бүх шатны эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлсэн.<br>Мөн Эрүүл мэндийн сайд, аймгийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээний эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлтийг сайжруулах дэмжлэг хяналтыг 2026 оны 04 дүгээр сараас 05 дугаар сарын хооронд Цагааннуур, Ерөө, Сайхан, Мандал бүсийн эрүүл мэндийн байгууллагуудад хуваарийн дагуу хийж, эрүүл мэндийн байгууллагуудад хэрэгжиж буй хууль, стандарт, тушаал, журам зааврыг танилцуулах, хэрэгжүүлэх тал дээр зөвлөн туслан ажиллаж байна.<br>Бүх шатны эрүүл мэндийн байгууллагуудад Эрүүл мэндийн газрын даргын баталсан долоо хоног бүрийн 4 дэх өдрийн 16 цагт тогтмол хийж байгаа “Цаг үеийн мэдээлэл” цахим хурлаар Хяналт шалгалтын хэлтсийн дарга, улсын ахлах байцаагч халдварын хяналт, сэргийлэлтийн чиглэлээр хяналт шалгалт хийсэн тайлан, гарсан зөрчлийг танилцуулан цаашид хууль тогтоомж, тушаал шийдвэрийн хүрээнд ажил сайжруулах зэрэг зөвлөн туслах мэдээллийг өгч ажилласан.<br>Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Эрүүл мэндийн газрын даргын 2026 оны А/15 тушаалын хэрэгжилтийг ханган Олон улсын сувилагчдын өдрийг тохиолдуулан “Чадварлаг сувилагч” төвийн бүсийн мэргэжлийн ур чадварын тэмцээн, чуулганыг Монголын сувилагчдын нийгэмлэг /МСН/-тэй хамтран 2026 оны 04 сарын 16,17-ны өдрүүдэд зохион байгуулсан. Тус тэмцээн нь багийн мэндчилгээ /3 минутын контент/ эмнэлгийн тусламж үйлчилгээний хууль |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | эрхзүйн мэдлэг шалгах сорил, багийн асуулт хариулт, амилуулах тусламж үйлчилгээ, халдварын сэргийлэлт хяналтын чиглэлээр нийт 5 багийн 25 сувилагч ур чадварын тэмцээнд, хүндэт зочид төлөөлөгч эрүүл мэндийн байгууллагын удирдлагууд, эмч, эмнэлгийн тусгай мэргэжилтнийг хамруулан 100 гаруй мэргэжилтэнд зохион байгуулсан.<br>Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/112 тушаалын хэрэгжилтийг ханган ЭХЭМҮТ-ийн Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, чанар аюулгүй байдлын албаны Эрсдэлийн менежер С.Дуламжав, Сувилахуйн албаны арга зүйч Б.Болорхорлоо нар "Үйлчлүүлэгчийн аюулгүй байдал", тохиолдол эрсдэлийг бүртгэх, мэдээлэх, хариу арга хэмжээ авах талаар онол, дадлага хосолсон хэлбэрээр хэлэлцүүлэг, ажлын байрны сургалтад Мандал бүсийн 93 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг танхимаар, 98 мэргэжилтэнг цахимаар нийт 191 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан.<br>**Хэрэгжсэн** |
| | 3.12.10 | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн томоохон тоног төхөөрөмжүүд болох Компьютерт томографын аппарат, Ангиографын аппарат, Хүчилтөрөгчийн бэсрэг үйлдвэр зэргийн засвар үйлчилгээ, сэлбэг | Улсын төсөв | Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлэх. | Иргэний эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмж сайжирсан байна | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн томоохон тоног төхөөрөмжүүд болох Компьютерт томографын аппарат, Хүчилтөрөгчийн бэсрэг үйлдвэр зэргийн засвар үйлчилгээ, сэлбэг хэрэгсэлд шаардлагатай төсвийг улсын төсөвт суулгасан. Аймгийн нэгдсэн эмнэлгийн хүчил төрөгчийн үйлдвэрийн засварт шаардлагатай хөрөнгийн асуудлыг Аймгийн удирдлагад хүсэлтийг уламжлан шийдвэрлүүлэхээр ажиллаж байна. Аймгийн нэгдсэн эмнэлэг "Биомед трейд" ХХК эмнэлгийн тоног төхөөрөмж ханган нийлүүлэх |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | хэрэгсэлд шаардлагатай төсвийг шийдвэрлэж, ашиглалт, аюулгүй ажиллагаанд байнгын хяналт тавьж, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх чиглэлээр дэмжлэг үзүүлж ажиллана. | | | | байгууллагатай хамтын ажиллагааны гэрээний байгуулсны үндсэн дээр нэгдсэн эмнэлгүүдийн тоног төхөөрөмжийн мэргэжилтнийг өөрсдийн зардлаар ажлын байрны дадлагажуулах сургалтад хамруулсан. Мандал сумын нэгдсэн эмнэлэгт мэргэжлийн тоног төхөөрөмжийн инженер ажиллаж байна.<br><br>**Хэрэгжсэн** |
| | 3.12.11 | “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 36.1.2-т заасны дагуу Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх тусламж, үйлчилгээнд хэрэглэх эм, эмнэлгийн хэрэгслийн тооцоо, судалгааг гарган Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны | 330сая | Эм, эмнэлгийн хэрэгслийн тооцоо судалгааг гаргаж худалдан авах ажиллагааг зохион байгуулан, зайлшгүй шаардлагатай эмийн хангалтын хувь, эмийн нөөцийг бүрдүүлсэн хувийг нэмэгдүүлэх | Эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авах ажиллагааг хуулийн хугацаанд зохион байгуулж эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх тусламж үйлчилгээнд шаардлагатай эмийн хангалт 95%-иас дээш, 3 сарын эмийн нөөцийн | 2026 онд 211 нэр төрлийн эмийг Эрүүл мэндийн яам, Сангийн яамтай хамтран ерөнхий гэрээгээр (онлайн) худалдан авалтын үйл ажиллагааг зохион байгуулж, “Цахим дэлгүүр”-т эмийн захиалгаа онлайнаар илгээж, захиалга батлагдсаны дараа гэрээний, маягтаар худалдан авах гэрээ байгуулан эм, эмнэлгийн хэрэглэлийг хანган нийлүүлж, тендерийн эмийн хангалт 100 хувь нийлүүлэгдэж, бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд эмийн 3 сарын нөөцөө бүрдүүлсэн.<br>Аймгийн хэмжээнд төр болон хувийн хэвшлийн 56 эмийн сан бүртгэлтэй байна.<br>Эм эмнэлгийн хэрэгслийн тухай хууль болон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эмийн эргэлтэнд тавих хяналтыг сайжруулан эмийн хангалтыг тендерээр нийлүүлж зарцуулалтын тайланг улирал тутам хүлээн авч нэгтгэн холбогдох газруудад хүргүүлэн ажилласан ба мансууруулах эмийн жор 130 ширхэг, сэтгэцэд нөлөөт эмийн жор 280 ширхэгийг кодлон эмнэлгүүдэд хүргүүлээд байна.<br>Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх заалт болон Эрүүл мэндийн сайдын 2023 оны 06 дугаар сарын 05- |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | байгууллагад тогтоосон хугацаанд хүргүүлнэ. | | | хангалтыг сайжруулан эмнэлгийн тусламж, үйлчилгээний бэлэн байдал бэхжүүлсэн байна. | ны өдрийн А/197 дугаар “Зайлшгүй шаардлагатай эмийн 10 дугаар жагсаалт батлах тухай” тушаалын дагуу зайлшгүй шаардлагатай эмийн 10 дугаар жагсаалтад орсон эм эмнэлгийн хэрэгслэлийн тасалдлын мэдээг бүх шатны эрүүл мэндийн байгууллагуудаас авч ажиллаж байна. **Хэргэжсэн** |
| | 3.12.12 | Иргэдийн дунд сайн дурын авлагагүй донорын эгнээг өргөжүүлж аюулгүй цус, цусан бүтээгдэхүүний бэлдмэлийн хангамжийг нэмэгдүүлнэ. | Улсын төсөв | Сайн дурын авлагагүй донорыг нэмэгдүүлсэн хувь | Сайн дурын авлагагүй донорыг нэмэгдсэн байна. | 2026 оны 6 дугаар сарын байдлаар нийт 110 хүнээс цус цуглуулж 271 нэгж цус цусан бүтээгдэхүүн үйлдвэрлэж, шинээр 16 донорыг элсүүлсэн.<br>Аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын ажилтан, албан хаагч нарт сайн дурын авлагагүй донор гэж хэн бэ?, донорын ач холбогдол, хэрхэн цусны авлагагүй донор болох сургалтыг зохион байгуулж 2 донор шинээр элсүүлсэн. Мөн жил бүр тэмдэглэн өнгөрүүлдэг 6 дугаар сарын 14-ны өдөр болох Дэлхийн цусны өдрийг угтан шинэ донор элсүүлэх ажлыг төлөвлөн ажиллаж байна. **Хэрэгжсэн** |
| | 3.12.13 | Алслагдсан сумдад жирэмсэн эх, хүүхэд, нөхөн үржихүйн амны хөндийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг өргөжүүлэн үзлэг оношилгоо эмчилгээний явуулын баг ажилуулан урьдчилан сэргийлэх эмчлэн эрүүлжүүлэх | Улсын төсөв | Урьдчилан сэргийлэх үзлэг хамрагдсан хүний тоо | Алслагдсан сумдын иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж нэмэгдсэн байна. | Алслагдсан сумдад 1002 өрхийн 2219 иргэнд жирэмсэн эх, хүүхэд, нөхөн үржихүйн амны хөндийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлж, үүнээс жирэмсэн 5, 0-5 насны 113, хөгжлийн бэрхшээлтэй 47, архаг суурь өвчтэй 89, ахмад настан 147 иргэнд явуулын нарийн мэргэжлийн эмчийн үзлэг болон хөнгөлттэй эмийн сангийн тусламж үйлчилгээг үзүүлсэн байна. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | арга хэмжээнд санхүүгийн дэмжлэг үзүүлэн зохи он байгуулан ажиллана. | | | | **Хэрэгжсэн** |
| | 3.12.14 | Харъяа нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагад зайлшгүй шаардлагатай (түргэн тусламжийн автомашин, тоног төхөөрөмж, барилга, засвар үйлчилгээний зардал) бусад дэмжлэгийг (багийн эмчийн унааны зардал) засаг даргын нөөц сан, Орон нутгийн төсвийн хөрөнгө, орон нутгийн хөгжлийн сангаас шийдвэрлэх арга хэмжээ авч ажиллана. | Улсын болон орон нутгийн төсөв | Хүлээлгэн өгсөн автомашины тоо<br>Засвар үйлчилгээ хийсэн барилгын тоо<br>Хангагдсан тоног төхөөрөмжийн хувь | 5<br>1<br>40% | Сайхан сумын Эрүүл мэндийн төвийн хэвтэн эмчлүүлэх тасгийн сантехникийн халаалтын шугам хоолойн засвар Аймгийн Засаг дарга, Орон нутгийн хөрөнгө оруулалтаар тендер зарлаж 05 сарын 01-ний өдрөөс эхэлсэн. Дотор, мэс заслын хэсгийн засвар дууссан.<br>Аймгийн нэгдсэн эмнэлэгт Төрөх, эмэгтэйчүүдийн тасгийн 257 сая төгрөгийн засварын ажил хийгдэнэ.<br>Аймгийн нэгдсэн эмнэлэгт Хандивлагч байгууллагаас 17 нэр төрлийн 23 ширхэг тоног төхөөрөмж, Мандал сумын нэгдсэн эмнэлэгт Засаг даргын нөөц сангаас 96,7сая төгрөгийн 71 нэр төрлийн 249 ширхэг, Хандивлагч байгууллагуудаас 79,7сая төгрөгийн 8 нэр төрлийн 24 ширхэг тоног төхөөрөмж, Сайхан сумын эрүүл мэндийн төвд Хандивлагч байгууллагаас 9 нэр төрлийн 23 ширхэг тоног төхөөрөмж, Түнхэл тосгоны эрүүл мэндийн төвд Мандал сумын засаг даргын тамгын газар, Хандивлагч байгууллагаас 19,2 сая төгрөгийн 13 нэр төрлийн 27 ширхэг тоног төхөөрөмжийг тус тус хүлээлгэн өгсөн.<br>**Хэрэгжсэн** |
| 3.13. Эрүүл мэндийн мэдээлэл технологи, цахим шилжилтийн чиглэлээр: | | | | | | |
| | 3.13.1 | Эрүүл мэндийн байгууллагад мэдээлэл, технологийн техник хангамж, | Улсын төсөв | Өндөр хурдны сүлжээнд холбогдож тоног төхөөрөмжөөр хангагдсан | 28 | Аймгийн хэмжээнд 28 эрүүл мэндийн байгууллага интернэт сүлжээгээр хангагч байгууллагатай гэрээ байгуулан өндөр хурдны интернэт сүлжээнд бүрэн холбогдсон.<br>**Хэрэгжсэн** |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | сүлжээ, програм хангамжийн дэд бүтцийг өргөжүүлэн бүх эрүүл мэндийн байгууллагыг өндөр хурдны интернэт сүлжээнд холбоно. | | байгууллагын тоо | | |
| | 3.13.2 | Эрүүл мэндийн байгууллага нь онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллага гэж Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 19.1.3 дахь заасны дагуу эрүүл мэндийн мэдээллийн аюулгүй байдал, мэдээллийн системийн өдөр тутмын үйл ажиллагааг явуулахад шаардлагатай сервер, тоног төхөөрөмжөөр ханган байнгын хяналт тавьж эрсдэлийн үнэлгээг хийлгэж зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана. | Улсын төсөв | Кибер аюулгүй байдал хангагдсан байгууллагын тоо | 2 | Аймгийн нэгдсэн эмнэлэг болон Мандал сумын нэгдсэн эмнэлэг нь Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 19.1.3 дахь заасны дагуу эрүүл мэндийн мэдээллийн аюулгүй байдал, мэдээллийн системийн өдөр тутмын үйл ажиллагааг явуулахад шаардлагатай сервер, тоног төхөөрөмжөөр ханган мэргэжлийн IT инженер хяналт тавьж системийн аюулгүй байдлыг хангаж ажиллаж байна. Одоогоор системд бүртгэгдсэн зөрчил халдлага бүртгэгдээгүй байна. Эрсдэлийн үнэлгээг хийлгэхээр Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Кибер аюулгүй байдлын бодлого зохицуулалтын газарт хүсэлтээ илгээгээд байна.<br>**Хэрэгжсэн** |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | 3.13.3 | Кибер аюулгүй байдлын сургалтад Лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагын мэдээллийн технологийн ажилтан, статистик мэдээллийн ажилчдыг улирал бүр хамруулна. | Улсын төсөв | Сургалтад хамрагдсан хүний тоо | 100 | Тагнуулын газраас зохион байгуулсан “Кибер аюулгүй байдал, мэдээллийн технологийн хамгаалалт” сургалтад аймгийн Нэгдсэн эмнэлэг, Мандал сумын Нэгдсэн эмнэлгийн мэдээллийн технологийн 3 ажилтан болон 15 сум 6 тосгон 5 өрхийн эрүүл мэндийн байгууллагын нийт 110 ажилчдыг цахимаар хамруулсан. **Хэрэгжсэн** |
| | 3.13.4 | Алсын зайн анагаах ухаан, телемедицины үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах тоног, төхөөрөмж хурдны интернэтээр хангаг ажиллана. | Улсын төсөв | телемедицины тоног, төхөөрөмжөөр хангагдсан байгууллагын тоо<br>өндөр хурдны интернэтээр хангагдсан байгууллагын тоо | 2<br><br>2 | Аймгийн нэгдсэн эмнэлэг Мандал сумын нэгдсэн эмнэлэг нь алсын зайн анагаах ухаан телемедцины үйлчилгээг лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллага Эх хүүхдийн үндэсний төвтэй 34 удаа холбогдож эх хүүхдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг авсан. Тусламж үйлчилгээг авах явцад өндөр хурдны интернэтээр бүрэн хангагдаж интернэтийн тасалдал үүсээгүй тусламж үйлчилгээг үзүүлэн ажилласан. **Хэрэгжсэн** |
| | 3.13.5 | Эм эмнэлгийн хэрэгсэлийн нөөц бүрдүүлэх тусламж үйлчилгээний иасралтгүй байдлыг хангах, хүн амд эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх эм эмнэлгийн хэрэгсэл, эрүүл мэдийн нэмэлт бүтээгдэхүүний мэдээллийн сан | Улсын төсөв | Эм эмнэлгийн хэрэгсэлийн мэдээллийн сан, эмийн нөөц бүрдүүлэх, тусламж үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах | Эм эмнэлгийн хэрэгслийн нөөц бүрдэлт, тусламж үйлчилгээн ий тасралтгүй байдал, эмийн зохистой хэрэглээ, мэдээ | Эрүүл мэндийн сайдын 2023 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн А/197 дугаар “Зайлшгүй шаардлагатай эмийн 10 дугаар жагсаалт батлах тухай” тушаалын дагуу зайлшгүй шаардлагатай эмийн 10 дугаар жагсаалтад орсон эм эмнэлгийн хэрэгслэлийн тасалдлын мэдээг бүх шатны эрүүл мэндийн байгууллагуудаас авч ажиллан, одоогоор эмийн 2 сарын нөөцтэй байна.<br>Мөн Эрүүл мэндийн сайдын 2009 оны А/388 дугаар “Амин чухал эм, эмнэлгийн хэрэгслийн хангамжийг зохицуулах журам батлах тухай” тушаалын дагуу ерөнхий гэрээгээр (онлайн) худалдан авалтын үйл ажиллагааг зохион байгуулж, “Цахим дэлгүүр”-ээс амин чухал эм, |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | бүрдүүлэх, мэдээ мэдээллийн шуурхай байдлыг ханган ажиллана. | | | мэдээллийн сан бүрдсэн байна. | эмнэлгийн хэрэгслийг худалдан авч 3 сараар нөөцийг бүрдүүлж байна.<br>Эрүүл мэндийн байгууллагуудын цахим хуудас болон фейсбүүк хуудсаар дамжуулан эмийн зохистой хэрэглээ, эмийн үнэ, чанарыг асуудлыг шийдэхэд иргэдийн хяналт хийх цахим хуудсыг таниулах, ашиглах мэдээллийг нийт 420 иргэд хүргэсэн байна.<br>**Хэрэгжсэн** |
| 3.14. Хүний нөөцийн чиглэлээр: | | | | | | |
| | 3.14.1 | Эрүүл мэндийн ажилтны нийгмийн баталгааг сайжруулан, орон нутагт тогтвор суурьшилтай ажиллах чиглэлээр орон сууц, гэрээр хангах, малжуулах арга хэмжээ хэрэгжүүлнэ. | Улсын төсөв | Эрүүл мэндийн ажилтны нийгмийн баталгааг сайжруулах | Эрүүл мэндийн ажилтны нийгмийн баталгаа хангадсан байна. | Эмч эмнэлгийн мэргэжилтэнг хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажиллуулах ажлын хүрээнд эрүүл мэндийн тухай хуулийн 29.5 дах заалтын дагуу 141 эмч, эмнэлгийн мэргэжилтэнд 1,166,442,000 төгрөг, 29.2 дах заалтын дагуу 38 хүнд 1,333,437,681 төргийн тэтгэмжийг олгосон байна.<br>Орон сууцны зээлд шинээр 11 албан хаагчийг хөнгөлөлттэй нөхцөлөөр, иж бүрэн гэрээр 3 албан хаагчид дэмжлэг үзүүлсэн байна.<br>**Хэрэгжсэн** |
| | 3.14.2 | Хөдөлмөрийн тухай хуулийн 145.4-т заалтын дагуу ахмад настныг ажлын байраар ханган, хүний нөөцийн дутагдалтай байдлыг шийдвэрлэн ажиллана. | Улсын төсөв | Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийн хувь, тоо | Ахмад настан ажлын байраар хангагдсан байна. | Сэлэнгэ аймгийн эрүүл мэндийн салбарт 55-59 нас 119 хүн буюу 9% , 60 наснаас дээш нас 72 хүн буюу – 5%-г эзэлж байна.<br>Салбарын хэмжээнд тэтгэвэрт гараад ажиллаж байгаа 12 их эмч, 26 сувилагч, 12 тусгай мэргэжилтэн ажиллаж нарийн мэргэжлийн хүний нөөцийн дутагдалтай байдлыг шийдвэрлэн ажиллаж байна.<br>**Хэрэгжсэн** |
| | 3.14.3 | Эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудыг ажиллангаа суралцан мэргэжил дээшлүүлэх, үндсэн | Улсын төсөв | Сургалтад хамрагдсан эмч, эмнэлгийн мэргэжилтний тоо | Эмч, эмнэлгийн мэргэжилтэ н тасралтгүй сургалтад | Ажлын байрны сургалтад давхардсан тоогоор 5170, зайн буюу телемедицины сургалтад давхардсан тоогоор 862 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан.<br>Эрүүл мэндийн ажилтныг гадаад сургалтад хамруулахаар төлөвлөсний дагуу Эрүүл |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | болон төрөлжсөн мэргэшил эзэмших, мэдлэг, ур чадварыг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн гадаад, дотоод сургалтад хамруулах болон эрүүл мэндийн удирдах ажилтнуудыг үе шаттайгаар бэлтгэн ур чадварыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. | | | хамрагдаж мэдлэг, чадвар дээшилсэн байна | мэндийн хөгжлийн төв, Эрүүл мэндийн яамнаас зохион байгуулсан сургалтад хуваарийн дагуу БНХАУ-ын Хөх хот, Тайвань, БНСУ, Сингапурт нийт 29 их эмч, эмнэлгийн мэргэжилтэнг гадаад сургалтад хамруулсан байна<br>Эрүүл мэндийн салбарын удирдах ажилтнуудыг чадавхжуулах ажлын хүрээнд Сумын эмч мэргэжилтнүүдийн холбоотой хамтран Улаанбаатар хотод “Сумын эрүүл мэндийн төвийн удирдлагын хөгжил” сэдэвт сургалтад Орхон, Дулаанхаан, Ерөө, Шаамар, Сант, Хушаат, Баянгол, Цагааннуур зэрэг нийт 8 сумын эрүүл мэндийн төвийн даргыг хамруулсан.<br>”Эрүүл мэндийн салбарын авлигын эсрэг 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-ны хэрэгжилтийг ханган ажиллах ажлын хүрээнд Авлигатай тэмцэх газар, Аймгийн Засаг даргын тамгын газартай хамтран Авлигын эсрэг хуулийн хориглолт, хязгаарлалт, хэрэгжилтийн талаарх цахим сургалтыг зохион байгуулж нэгдсэн эмнэлгүүд, сум, тосгоны эрүүл мэндийн төвүүдийн дарга, санхүүгийн албаны холбогдох албан тушаалтан нийт 28 нэгжээс 186 хүнийг хамруулсан.<br>**Хэрэгжсэн** |
| | 3.14.4 | Аймгийн нэгдсэн эмнэлгийг ерөнхий мэргэшил судлалаар сургалт эрхлэх байгууллага болгон бэлтгэж, шаардлагатай хөрөнгө оруулалтыг | Улсын төсөв | Эмнэлзүйн сургагч багшаар бэлтгэгдсэн эмч, эмнэлгийн мэргэжилтний тоо | Орон нутагтаа ерөнхий мэргэшил судлалаар их эмчийг бэлтгэн их эмчийн | Аймгийн нэгдсэн эмнэлгийг сургалт эрхлэх байгууллага болгох зорилтын хүрээнд бэлтгэгдсэн эмнэлзүйн сургагч багш 7 байна. Сургагч багшийг орон нутагт бэлтгэх зорилгоор Эрүүл мэндийн хөгжлийн төвд хүсэлт тавьж нийт 25 эмч эмнэлгийн мэргэжилтэнг бэлтгэхээр ажиллаж байна.<br>**Хэрэгжсэн** |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | шийдвэрлэж, орон нутгийн эрүүл мэндийн байгууллагад шаардлагатай хүний нөөцийг мэргэшүүлэн бэлтгэх арга хэмжээг хамтран хэрэгжүүлж дэмжлэг үзүүлнэ. | | | дутагдал нөхөгдсөн байна | |
| | 3.14.5 | Нийгмийн эрүүл мэндийн төв, анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудыг нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэнээр хангах, тэднийг сурхад дэмжлэг үзүүлнэ. | Улсын төсөв | бэлтгэгдсэн эмч, эмнэлгийн мэргэжилтний тоо | Эмнэлгийн мэргэжилтэний дутагдал нөхөгдсөн байна | Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөн, аймгийн ИТХ-ын 2026 оны 77 дугаар тогтоолоор батлагдсан "Чадварлаг эмч, чадварлаг сувилагч, чадварлаг эмнэлгийн мэргэжилтэн" хөтөлбөрийн хүрээнд ОЛОН НИЙТИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛТАН БЭЛТГЭХ, сургагч багш нарыг чадавхижуулах сургалтыг 2026 оны 04 сарын 07-09-ны өдрүүдэд Эрүүл мэндийн газрын сургалтын танхимд зохион байгуулсан.<br>Тус сургалтыг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн дэмжлэгтэйгээр Эрүүл мэндийн газар, Алтанбулаг, Жавхлант сумын Эрүүл мэндийн төв, Сүхбаатар сумын Номтхан, Эмнэх өрхийн эрүүл мэндийн төв, Мандал сумын Хараа манал, Ачит амирлуулагч, Үйлст эмнэхүй өрхийн эрүүл мэндийн төвүүд хамтран зохион байгуулсан ба 34 олон нийтийн эрүүл мэндийн ажилтан бэлтгэгдсэн.<br>Сургалтад оролцогчид эрүүл мэндийн салбарын мэдээллийг “айдас” төрүүлэх бус, иргэдийн зан үйлийг өөрчлөх, зөв дадал төлөвшүүлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр дамжуулах арга зүйд суралцсанаараа онцлог болсон.<br>Эрүүл мэндийн газраас 17 сум, 6 тосгон, 5 өрхийн эрүүл мэндийн байгууллагуудаа 7 хоног |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тутамд цаг үеийн мэдээ, мэдээллийг шуурхай хүргэх, харилцан мэдээлэл солилцох зорилгоор ЦАХИМ ХУРАЛ, УУЛЗАЛТЫГ зохион байгуулж хэвшсэн.<br>Нийгмийн эрүүл мэндийн төвийн сар бүрийн Нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтнүүдийг чадавхижуулах 12 удаагийн сургалтад 145 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан байна.<br>**Хэрэгжсэн** |
| 3.15 Бусад үйл ажиллагааны чиглэлээр | | | | | | |
| | 3.15.1. | Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын дүнг Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэн харьяалах нутаг дэвсгэрт эрүүл мэндийн чиглэлээр илэрч буй зөрчлийг арилгуулах, үүсэж болзошгүй эрсдэлээс сэргийлэх, эрсдэлийг бууруулах чиглэлээр арга хэмжээ авч ажиллана. | Улсын төсөв | Эрсдэлийн түвшин хувиар<br><br>Хууль сахин мөрдөлт хувиар | 1% хүртэлх бууруулна.<br><br>1% хүртэлх өсгөнө. | Монгол Улсын Эрүүл мэндийн сайд аймгийн Засаг даргатай 2026 хамтран ажиллах гэрээний 3.15.2-т тусгагдсан заалтын хэрэгжилт, харьяалах нутаг дэвсгэрийн хүн амыг эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хануулах зорилгоор Хяналт шалгалтын хэлтсийн 2023-2025 оны салбарын хяналт шалгалтын тайланг харьцуулсан үзүүлэлтээр гаргаж 2026 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр Засаг даргын дэргэдэх Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн.<br>Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын чиглэлээр тайлангийн хугацаанд төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус болон урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх 11 удирдамжийн хүрээнд нийт 114 объектын хамруулахад эрсдэл үүсэх магадлал дунджаар 44.9%, хууль сахин мөрдөлт 55.1%-тай өмнөх оны тоон үзүүлэлттэй харьцуулахад эрсдэл үүсэх магадлал 5.3%-иар буурч, хууль сахин мөрдөлт 5.3%-иар нэмэгдсэн байна.<br>Хүнс, орчин, хүүхэд, өсвөр үеийн эрүүл ахуй болон эрүүл мэндийн байгууллагын халдвар хамгааллын хяналтын чиглэлээр тайлангийн хугацаанд үүсч болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх, үйл ажиллагааны онцлогт тохируулан дотоод хяналтыг тогмтолжуулах, ажлын байранд |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | эрүүл ахуйн зохистой дадлыг хэвшүүлэх, цаашлаад эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвараас урьдчилан сэргийлэхэд анхаарах асуудлын хүрээнд танхимын 4 сургалтад 2 аж ахуйн нэгж, 2 байгуулагын 218 ажиллагсад, цахим сургалтыг 2 удаагийн давтамжтай давхардсан тоогоор 52 байгууллагын 131 эмч, эмнэлгийн ажиллагсдад нийт 349 холбогдох албан тушаалтнуудад, улсын ахлах байцаагчийн 26 заалт бүхий 3 зөвлөмж, 1 албан тоотыг 97 төрийн байгууллагуудад цахимаар хүргүүлж нийт 103 103 аж ахуйн нэгж, байгууллагын 446 холбогдох албан тушаалтанд мэргэжил арга зүйн зөвлөгөө, зөвлөмжөөр хангаж ажилласан байна. **Хэрэгжсэн** |
| | 3.15.2. | Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 184 дүгээр “Хяналт шалгалтын 2026 оны төлөвлөгөө батлах тухай” тогтоол, Эрүүл мэндийн яамны 2026 оны хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөөний хэрэгжилтийг харьяалах нутаг дэвсгэртээ хангуулж, хяналт шалгалтын дүнг Засаг даргын зөвлөлийн хурлаар | Улсын төсөв | Объектын хамрагдалт<br><br>Эрсдэлийн түвшин хувиар<br><br>Хууль тогтоомжийн хэрэгжилт хувиар | 100%<br><br>1.5% хүртэлх бууруулна.<br><br>1.5% хүртэлх нэмэгдүүлнэ. | Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын чиглэлээр тайлангийн хугацаанд төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус болон урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх 11 удирдамжийн хүрээнд нийт 114 объектын хамруулж, хяналт шалгалтын явцад 13 аж ахуйн нэгжид 29.500.000 төгрөгийн шийтгэлийн арга хэмжээ авч 7 нэр төрлийн 67 ширхэг 402.400 төгрөгийн хэрэглэж дуусах хугацаа хэтэрсэн хүнсний бүтээгдэхүүнийг аймгийн Засаг даргын дэргэдэх орон тооны бус зөвлөлд устгах шийдвэр гаргуулахаар хугацаанд нь шилжүүлсэн.<br>Хяналт шалгалтын явцад нийт улсын ахлах байцаагчийн 10 зөвлөмж, 216 заалт бүхий 14 албан шаардлага, үйл ажиллагаа түр зогсооон акт 1, үйл ажиллагааг сэргээсэн 1 актыг үйлдэж хэрэгжилтийг хангуулж, эрсдэл үүсэх магадлал дунджаар 44.9%, хууль сахин мөрдөлт 55.1%-тай өмнөх оны тоон үзүүлэлттэй харьцуулахад эрсдэл үүсэх магадлал 5.3%-иар буурч, хууль |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | хэлэлцэж, харьяалах нутаг дэвсгэртээ илэрч буй зөрчил дутагдлыг арилгуулах, үүсэж болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах чиглэлээр бодлого зохицуулалтын арга хэмжээ авч ажиллана. | | | | сахин мөрдөлт 5.3%-иар нэмэгдсэн байна.<br>Цаашид бүх шатны төрийн болон хувийн хэвшлийн иргэн, аж ахуйн нэгж байгууллагудад хуулийн хэрэгжилтийг нэмэгдүүлэх зорилгоор танхимын болон цахим сургалт зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.<br><br>**Хэрэгжсэн** |
| | 3.15.3. | Үндэсний хэмжээнд эрүүл мэндийн чиглэлээр гэрээний хугацаанд одоо хэрэгжиж байгаа болон шинээр батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөр арга хэмжээг орон нутгийн түвшинд хэрэгжүүлж салбар дундын уялдааг ханган хамтран ажиллана. | **Улсын төсөв** | Салбар дундын хамтын ажиллагаатай зохион байгуулсан арга хэмжээний тоо | 10 | Эрүүл идэвхтэй амьдралын хэв маягийг төлөвшүүлж Эрүүл шүд, Эрүүл настан, идэвхитэй насжилтыг дэмжих, Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, Сэтгэцийн эрүүл мэнд, Жендерт суурилсан болон гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, сэргийлэх, Элэг бүтэн Монгол, Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх зэрэг 18 арга хэмжээнүүдийн хүрээнд аймгийн ЗДТГ, Хөдөлмөр халамж үйлчилгээний газар, Хүүхэд гэр бүл хөгжил хамгааллын газар, Боловсролын газар, Цагдаагийн газар, Онцгой байдлын газар бусад төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран дараах ажиллуудыг зохион байгуулж ажиллаж байна. Үүнд:<br><br>1. Гамшгаас хамгаалах эрүүл мэндийн болон сурталчилгааны албаны сургалт<br>2. Хаалганаас хаалганд сүрьеэгийн эрт илрүүлэг үзлэг<br>3. Японы хүүхдийг ивээх сангийн “Тэгш хүртээмжтэй, цогц үйлчилгээгээр бага |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | насны хүүхдийг дэмжих нь” төслийн “Эрт анхааръя” олон нийтэд чиглэсэн нөлөөллийн үйл ажиллагаа<br>4. Гаалийн газартай хамтран ширээний дасгал сургуулилт<br>5. Боловсролын газартай хамтран Хүний папиллома вирусийн эсрэг дархлаажуулалт<br>6. УИХ-ын гишүүн Ундрамын нэрэмжит Марафон гүйлтийн тэмцээн<br>7. Хөдөлмөр халамж үйлчилгээний газартай хамтарсан “Ахмад насны цогц үзлэг”<br>8. Чадварлаг сувилагч 2026 арга хэмжээ<br><br>**Хэрэгжсэн** |
| | 3.15.4. | Засаг даргын зөвлөлийн хурлаар дараах асуудлуудын хэрэгжилтийг хэлэлцэн тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэж санал санаачлагатай ажиллана. Үүнд:<br>✓ Үндэсний хэмжээнд эрүүл мэндийн чиглэлээр гэрээний хугацаанд | Улсын төсөв | Ирүүлсэн хүсэлтийн тоо<br><br>Шийдвэрлэлтийн хувь | Тухай бүр | Монгол Улсын Эрүүл мэндийн сайд аймгийн Засаг даргатай 2026 хамтран ажиллах гэрээний 3.15.2-т тусгагдсан заалтын хэрэгжилт, харьяалах нутаг дэвсгэрийн хүн амыг эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хануулах зорилгоор Хяналт шалгалтын хэлтсийн 2023-2025 оны салбарын хяналт шалгалтын тайланг харьцуулсан үзүүлэлтээр гаргаж 2026 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр Засаг даргын дэргэдэх Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн.<br>Чадварлаг эмч, чадварлаг сувилагч, чадваралаг эмнэлгийн мэргэжилтэн хөтөлбөрийг А=мйгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэн 2026 оны 1 дүгээр сарын 30- ны өдрийн 77 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | одоо хэрэгжиж байгаа болон шинээр батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөр арга хэмжээг<br>✓ Эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ оношилгооны явц, үр дүн<br>✓ Цахимжилт, Кибер аюулгүй байдал, мэдээллийн аюулгүй байдал<br>✓ Хүний нөөцийн тогтвор суурьшил, нийгмийн баталгааны дэмжих чиглэлээр хэрэгжүүлж буй арга хэмжээ<br>✓ Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд “Эрүүл | | | | дугаар тогтоолоор батлуулан хэрэгжүүлж байна.<br><br>**Хэргэжсэн** |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | мэндийн үйлчилгээнд тавих шаардлага" MNS 7014:2023 стандартын үнэлгээний дүнг хэлэлцэх<br>✓ Аймгийн эрүүл мэндийн газрын харъяанд Нийгмийн эрүүл мэндийн төвийг байгуулах бэлтгэл ажлийн төлөвлөгөө хэрэгжилт<br>✓ Эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилт<br>✓ Өрхийн эрүүл мэндийн байгууллагын гэрээний үүргийн хэрэгжилт<br>✓ Аймаг орон нутгийн онцлогоос шалтгаалсан тулгамдсан | | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | асуудлууд | | | | |

| | |
|---|---|
| Тайлан бичсэн: | П.Сэлэнгэ(НЭМТөвийн дарга) |
| | У.Энхбат(ХШХэлтсийн дарга) |
| | С.Азжаргал(ЭТҮХДаргын үүргийг түр орлон гүйцэтгэгч) |
| Тайлан нэгтгэсэн | У.Ууган-Эрдэнэ(УТСХДарга) |
| Хянасан | Ж.ОД (ЭМГ-ын дарга) |

Монгол Улсын Эрүүл мэндийн сайд,
Сэлэнгэ аймгийн Засаг
даргын хооронд байгуулсан
гэрээний хавсралт №1

**Сэлэнгэ аймгийн Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний үр дүнгийн шалгуур үзүүлэлт- /2026 оны хагас жилээр/**

| д/д | Шалгуур үзүүлэлт | Суурь үзүүлэлт /2024 он/ | Суурь түвшин /2025 он хагас жилээр/ | Хүрэх түвшин /2026 он/ | Биелэлт хагас жилээр | Үр дүн | Үнэлгээ |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлэгт хамрагдсан 18 ба түүнээс дээш насны хүн амын эзлэх хувь | 75.4 | 32.8 | 99.1 | 45.6 | 12.8 % өссөн үзүүлэлттэй байна. | 100 |
| 2 | Чихрийн шижин хэв шинж-2 өвчний эрт илрүүлэгт хамрагдсан 40 ба түүнээс дээш насны хүн амын эзлэх хувь | 92.9 | 30.7 | 102.1 | 43.9 | 13.2 % өссөн үзүүлэлттэй байна. | 100 |
| 3 | Хөхний өмөнгийн эрт илрүүлгийн үзлэгт хамрагдсан 30 ба түүнээс дээш насны эмэгтэйчүүдийн тоо | 2170 | 1331 | 14410 | 10879 | 9548 эмэгтэйгээр өссөн үзүүлэлттэй байна. | 100 |
| 4 | Умайн хүзүүний өмөнгийн эрт илрүүлэгт хамрагдсан 30 ба түүнээс дээш насны эмэгтэйчүүдийн эзлэх хувь | 28.2 | 25.9 | 42.2 | 31.7 | 5.8 % өссөн үзүүлэлттэй байна. | 100 |
| 5 | Урьдчилан сэргийлэх үзлэгийн хувь | 30.9 | 29.4 | 38.2 | 38.6 | 9.2% өссөн үзүүлэлттэй байна | 100 |
| 6 | В вируст хепатитын эсрэг сэргийлэх тарилгын 24 цагийн хамралтын хувь | 99.9 | 100 | 101.5 | 100 | Адил түвшинд байна | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 7 | Тавт, сахуу, хөхүүл ханиад, татран, В хепатит сэргийлэх тарилгын хамралтын хувь-3-р тун | 100 | 100 | 102 | 100 | Адил түвшинд байна. | 100 |
| 8 | Улаанбурхан, гахайн хавдар, улаануудын эсрэг сэргийлэх тарилгын хамралтын хувь-2-р тун | 100 | 100 | 102.2 | 100 | Адил түвшинд байна | 100 |
| 9 | Эхийн эндэгдлийн түвшин /100,000 амьд төрөлт тутамд/ | 90.7 | 233.1 | 97.9 | 0 | 97,9-аар буурсан үзүүлэлттэй | 100 |
| 10 | Нялхсын эндэгдлийн түвшин /1000 амьд төрөлт тутамд/ | 7.3 | 9.8 | 10.8 | 5.5 | 4,3-аар буурсан үзүүлэлттэй | 100 |
| 11 | Нярайн эндэгдлийн түвшин /1000 амьд төрөлт тутамд/ | 4.5 | 7 | 6.9 | 2.7 | 4,3-аар буурсан үзүүлэлттэй | 100 |
| 12 | Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин /1,000 амьд төрөлт тутамд/ | 11.8 | 21 | 16.7 | 8.2 | 12,8-аар буурсан үзүүлэлттэй байна | 100 |
| 13 | Амьгүй төрөлтийн түвшин /1,000 төрөлт тутамд/ | 3.6 | 3.9 | 4.9 | 3.4 | 0,5 % буурсан үзүүлэлттэй байна | 100 |
| 14 | Жирэмсний эхний 3 сард хяналтад орсон эхийн эзлэх хувь | 89.9 | 86.6 | 93.8 | 93.0 | 6.4%-аар өссөн үзүүлэлттэй | 100 |
| 15 | Өсвөр насны 1000 эмэгтэйд ногдох төрөлтийн түвшин | 6.0 | 1.1 | 5.1 | 0.6 | 0,5 буурсан үзүүлэлттэй байна | 100 |
| 16 | Сүрьеэгийн өвчлөлийн түвшин /10,000 хүн амд/ | 9.1 | 3.9 | 7.5 | 6.2 | 2,3-аар өссөн үзүүлэлттэй байна | 0 |
| 17 | Вирүст гепатитын өвчлөлийн түвшин /10,000 хүн амд/ | 0 | 0 | 0 | 0 | Адил түвшинд байна | 100 |
| 18 | Зүрх судасны өвчлөлөөс шалтгаалсан нас баралтын түвшин /10,000 хүн амд/ | 19.4 | 9.9 | 17.9 | 7.1 | 2,8-аар буурсан үзүүлэлттэй байна | 100 |
| 19 | Хорт хавдраас шалтгаалсан нас баралтын түвшин /10,000 хүн | 14.3 | | 12.6 | 5.5 | 2,1-ээр буурсан үзүүлэлттэй байна | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | амд/ | | 7.6 | | | | |
| 20 | Амиа хорлож нас барсан тохиолдлын түвшин /10,000 хүн амд/ | 2 | 1.1 | 1.9 | 0.7 | 0,4-өөр буурсан үзүүлэлттэй байна | 100 |
| 21 | Санамсаргүй хордох, хорт бодист өртсөнөөс шалтгаалсан нас баралтын түвшин /10,000 хүн амд/ | 2.4 | 1.1 | 3.0 | 2.3 | 1,2-оор өссөн үзүүлэлттэй байна | 0 |
| 22 | 0-5 хүртэлх насны хүүхдийн түлэгдэлтийн түвшин /10,000 хүүхдэд T20-T32/ | 77.6 | 27.9 | 94.3 | 35 | 7,1-ээр өссөн үзүүлэлттэй байна | 0 |
| 23 | Хүүхдийн зам тээврийн ослын шалтгаант нас баралтын түвшин /10,000 хүүхдэд, V00-V99/ | 1.3 | 25.7 | 1.0 | 0 | 25,7-оор буурсан үзүүлэлттэй байна | 100 |
| **НЭМЭЛТ** | | | | | | | |
| 24 | Чихрийн шижингийн шалтгаанд нас баралтын түвшин 10000 хүнд | 1.0 | 0.3 | 0.8 | 0.4 | 0,1-ээр өссөн үзүүлэлттэй байна. | 100 |
| 25 | Амьсгалын замын архаг өвчний шалтгаант нас баралтйн түвшин 10000 хүнд | 1.4 | 1 | 1.9 | 1.8 | 0,8-аар өссөн үзүүлэлттэй байна. | 0 |
| 26 | Сэргийлэх боломжтой эмнэлгийн бус нас баралтын нийт нас баралтын эзлэх хувь | 61.7 | 54.2 | 63.9 | 55.4 | 1,2%-аар өссөн үзүүлэлттэй байна | 95 |
| 27 | Халдварт өвчний тохиолдлын тоо 10000 хүнд | 48.6 | 21.4 | 57.3 | 30.3 | 8,9-өөр өссөн үзүүлэлттэй байна | 0 |
| 28 | Бүх хэлбэрийн сүрьеэгийн эмчилгээний амжилтийн хувь | 91.7 | 85.6 | 91 | 93.9 | 8,3-аар өссөн үзүүлэлттэй байна | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 29 | Үр хөндөлтийн харьцаа 1000 амьд төрөлтөд ногдох | 36.3 | 55.9 | 73.6 | 95.9 | 40-өөр өссөн үзүүлэлттэй байна | 0 |
| 30 | Жирэмсний хугацаанд 6 ба түүнээс дээш хяналтад хамрагдсан эмэгтэйчүүдийн хувь | 89.5 | 80.8 | 81.4 | 83 | 2,2-оор өссөн үзүүлэлттэй байна | 100 |
| Дундаж дүн | | | | | | | 79.8 |

---oOo---

Тайлан бичсэн: П.Сэлэнгэ(НЭМТөвийн дарга)

У.Энхбат(ХШХэлтсийн дарга)

С.Азжаргал(ЭТҮХДаргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Тайлан нэгтгэсэн У.Ууган-Эрдэнэ(УТСХДарга)

Хянасан Ж.ОД (ЭМГ-ын дарга)